

**“ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ” ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨРИЙН 2020 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

(2020 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл	
1	Хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар: ЗГ-ын 2018.12.26-ны өдрийн 400 дугаар тогтоол.	Хөтөлбөрийн зорилго: Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих төрийн бодлогын хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэлийг бүсчилж хөгжүүлэх, төрөлжүүлэн эрчимжүүлэх, төвлөрсөн хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтворжуулах, малын гаралтай зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг бууруулах, экспортыг дэмжих, эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх, тэдгээрийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн үр өгөөжийг сайжруулахад энэ хөтөлбөрийн зорилго оршино.	
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсөв, гадаадын төсөл (зээл), хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, буцалтгүй тусламж	
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Хэрэгжих хугацаа: I үе шат: 2019-2020 он. II үе шат: 2021-2023 он. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: МЭЕГ, яамны харьяа байгууллага, аймаг, сумын ЗДТГ.	
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. Эрчимжсэн мал аж ахуйн үйл ажиллагааг бүсчилж, төрөлжүүлэн кластер, ложистикийн сүлжээний үйлчилгээг хөгжүүлэх; Зорилт 2. Мал, амьтны гаралтай зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг бууруулах, экспортыг дэмжих дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах; Зорилт 3. Гойд ашиг шимт үржлийн мал, амьтны тоог нэмэгдүүлж, хот суурингийн хүн амын хүнсний хэрэгцээний сүү, мах, өндөг, зөгийн бал болон бусад түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл хангамжийг сайжруулах; Зорилт 4. Эрчимжсэн мал аж ахуйн техник, технологийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, бүтээмж үр ашгийг нь нэмэгдүүлэх; Зорилт 5. Боловсруулах үйлдвэрт нийлүүлэх мах, сүүний улирлын хамаарлыг бууруулах, аюулгүй байдлыг бүртгэлээр баталгаажуулах; Зорилт 6. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн санаачлага хөрөнгө оруулалыг урт хугацааны хөнгөлөлттэй зээл, татварын бодлогоор дэмжих; Зорилт 7. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн технологи, эдийн засгийн мэдлэгийг сайжруулах, чадавхижуулах;	
5.	Зардал	Төсөв	
		Үүнд	Төсөв (2020 он) сая төг
		Улсын төсөв	319.9
		Орон нутаг	710.0
		Төсөл, хөтөлбөр	412.9
		Хувийн	8300.0
		Нийт	9742.8
6.	Хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.	
	1 дүгээр зорилт	Биелэлт 8-11 дугаар хуудас	
	2 дугаар зорилт	Биелэлт 11-16 дугаар хуудас	
	3 дугаар зорилт	Биелэлт 16-20 дугаар хуудас	
	4 дүгээр зорилт	Биелэлт 20-26 дугаар хуудас	
	5 дугаар зорилт	Биелэлт 26-28 дугаар хуудас	
	6 дугаар зорилт	Биелэлт 28-29 дугаар хуудас	
	7 дугаар зорилт	Биелэлт 29-33 дугаар хуудас	
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Дүгнэлт: Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар 62.3 хувь, 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 75.0 хувьтай байна. Үүнээс 24 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, тодорхой үр дүнд хүрсэн 29 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай 17 арга хэмжээ байна.	

	<p>Ковид-19 цар тахал, төсвийн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалж зарим арга хэмжээний хэрэгжилт удааширч хойшлогдсон, санхүүжилт тавигдаагүй тул 2020 оны хэрэгжилт өмнөх оноос 3.8%-иар буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>Зөвлөмж: Хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг боловсруулж улсын төсөвт суулгаж ажиллахыг СХОГ, МААБХЗГазарт; Аймаг, орон нутгийн мэргэжлийн байгууллага болон харьяа байгууллагын хэрэгжилтийн тайланг нэгтгэж, зохион байгуулсан арга хэмжээг улсын хэмжээнд нэгтгэн дүгнэж төсвийн эх үүсвэрийн хамт тодорхой тайлагнахыг холбогдох бүх газарт; Тухайн жилийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шатанд учирч болох эрсдийг урьдчилан тооцоолох, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэнтэй хамтран ажиллахыг холбогдох бүх газарт; Тухайн жилийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэх салбарын бүх байгууллагуудад хүргүүлэх, арга хэмжээ бүрт хариуцан ажиллах байгууллага, албан тушаалтныг тусгаж ажиллахыг холбогдох бүх газарт; Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хөтөлбөрийн хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнаж, цахим санд баталгаажуулахыг холбогдох бүх газарт;</p>																		
8	<p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ</p> <p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэгчдийн хамтын ажиллагаа дунд байна.</p>																		
9	<table border="1"> <tr> <td>Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)</td> <td>Биелэлт дундаж</td> <td>1</td> <td>2</td> <td>3</td> <td>4</td> <td>5</td> <td>6</td> <td>7</td> </tr> <tr> <td></td> <td>75.0</td> <td>71.3</td> <td>76.4</td> <td>70</td> <td>86.9</td> <td>73.3</td> <td>60</td> <td>78</td> </tr> </table>	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	1	2	3	4	5	6	7		75.0	71.3	76.4	70	86.9	73.3	60	78
Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	1	2	3	4	5	6	7											
	75.0	71.3	76.4	70	86.9	73.3	60	78											
10	<p>Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)</p> <p>Нэгдсэн үнэлгээ</p> <p>... %</p>																		

ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН 2020 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021 оны 03 дугаар сарын 30

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийв. ХХААХҮ Яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдөр баталсан хөтөлбөрийн 2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтийг үндэслэж асуудал хариуцсан мэргэжилтнүүдээс шаардагдах тодруулга, холбогдох мэдээлэл, статистик дүнг гаргуулан ажиллав.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 400 дугаар тогтоолоор, хөтөлбөрийн хүрээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 2019-2023 оны хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг ХХААХҮ-ийн сайдын 2019 оны “Төлөвлөгөө батлах тухай” А-120 дугаар тушаалаар тус тус баталсан.

2.1. Хөтөлбөрийн зорилго

Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн зорилго нь ХХАА-н үйлдвэрлэлийг дэмжих төрийн бодлогын хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэлийг бүсчилж хөгжүүлэх, төрөлжүүлэн эрчимжүүлэх, төвлөрсөн хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтворжуулах, малын гаралтай зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг бууруулах, экспортыг дэмжих, эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх, тэдгээрийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн үр өгөөжийг сайжруулахад энэ хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн үндсэн чиглэл

1. Эрчимжсэн мал аж ахуйн үйл ажиллагааг бүсчилж, төрөлжүүлэн кластер, ложистикийн сүлжээний үйлчилгээг хөгжүүлэх;
2. Мал, амьтны гаралтай зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг бууруулах, экспортыг дэмжих дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах;
3. Гойд ашиг шимт үржлийн мал, амьтны тоог нэмэгдүүлж, хот суурингийн хүн амын хүнсний хэрэгцээний сүү, мах, өндөг, зөгийн бал болон бусад түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл хангамжийг сайжруулах;
4. Эрчимжсэн мал аж ахуйн техник, технологийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, бүтээмж үр ашгийг нь нэмэгдүүлэх;
5. Боловсруулах үйлдвэрт нийлүүлэх мах, сүүний улирлын хамаарлыг бууруулах, аюулгүй байдлыг бүртгэлээр баталгаажуулах;
6. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн санаачлага хөрөнгө оруулалыг урт хугацааны хөнгөлөлттэй зээл, татварын бодлогоор дэмжих;
7. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн технологи, эдийн засгийн мэдлэгийг сайжруулах, чадавхжуулах;

2.3. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа

- Эхний үе шат /2019-2020 он/,
- Хоёр дахь үе шат /2021-2023 он/.

2.4. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

1. Эрчимжсэн мал аж ахуйн зохион байгуулалтыг төрөлжүүлж, кластер, ложистикийн сүлжээг бий болгоно.
2. Импортоор авч байгаа малын гаралтай зарим нэр төрлийн бүтээгдэхүүнийг 15-100 хүртэл хувиар багасгаж, 4 хүртэлх нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг тэглэж, гадагш урсах валютын урсгалыг бууруулна.
3. Гойд ашиг шимт мал, амьтны тоог нэмэгдүүлж, төвлөрсөн хүн амын хэрэгцээний сүү, мах, өндөг, зөгийн балны дотоодын үйлдвэрлэл, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
4. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлээр дамжуулан боловсруулах үйлдвэрт нийлүүлэх мах, сүүний улирлын хамаарлыг бууруулж, хүнсний аюулгүй байдлыг бүртгэлээр баталгаажуулдаг болно.
5. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн техникийн шинэчлэлийг 50 хүртэл хувьд хүргэнэ.
6. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх эрх зүй, хөрөнгө оруулалт, татварын таатай орчинг бүрдүүлж, энэ чиглэлийн үйлдвэрлэл эрхлэгчдийн эдийн засгийн үр өгөөж, орлогыг нэмэгдүүлнэ.
7. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн бизнесийн болон технологийн мэдлэг чадварыг тогтмол дээшлүүлж, хөдөлмөрийг үнэлэх, урамшуулах системд шилжүүлж, чадавхжуулна.

ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар 62.3 хувьтай байна.

Хүснэгт 2

№	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин 2020 он	Хүрсэн түвшин	Үнэлгээ
1	Нийт мал сүрэг дэх өндөр ашиг шимт мал, амьтны эзлэх хувь	2.5	2.3	92.0
2	Мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүний импортын үнийн өөрчлөлт (сая ам.доллар)	119.2	102.0	85.6
3	Сүүний болон хосолмол ашиг шимт үхрийн тооны өөрчлөлт (мян.толгой)	82.4	97.3	100
4	Эрчимжсэн аж ахуйгаас нийлүүлэх сүүний хэмжээ (мян.литр)	222.5	225.0	100
5	Нэг үнээнээс жилд авах сүүний хэмжээ (литр)	2700	2740	100
6	Импортын шингэн сүүний бууралт (мян.тонн)	3.5	0	0
7	Импортын хуурай сүүний бууралт (мян.тонн)	22.9	0.5	2.2

8	Махны чиглэлийн үхрийн тооны өөрчлөлт (мян.толгой)	19.8	28.6	100
9	Гахайн тооны өөрчлөлт (мян.толгой)	37.0	22.3	60.3
10	Гахайн мах, өөх үйлдвэрлэлийн хэмжээ (тонн)	34.7	0	0
11	Гахайн мах, өөхний импортын хэмжээний бууралт (тонн)	4.1	0	0
12	Өндөг үйлдвэрлэлийн хэмжээний өсөлт (сая. ширхэг)	155.0	173.2	100
13	Өндөгний импортын бууралт (сая.ширхэг)	48.0	0	0
14	Зөгийн бүлийн тооны өсөлт (мянга)	13.5	13.5	100
15	Зөгийн бал үйлдвэрлэлийн хэмжээний өсөлт (тонн)	255.0	15.0	6.0
16	Зөгийн балны импортын бууралт (тонн)	160.5	98.2	61.2
17	Экспортолсон зөгийн балны хэмжээ (хувь)	4.0	0	0
18	Тэжээлийн ургамал тариалсан талбайн өсөлт (мянган га)	55.0	58.0	100
19	Хүчит тэжээл үйлдвэрлэлийн хэмжээ (тонн)	135.0	141.9	100
20	Зохиомол хээлтүүлгийн үйлчилгээ үзүүлсэн малын тоо (мянган толгой)	6.5	6.9	100
21	Туршлага судалсан, сургалтад хамрагдсан эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн тоо	350.0	1700	100
				62.3

Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн 2020 оны арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр нийт 70 арга хэмжээнээс 24 арга хэмжээ 100 хувь, 4 арга хэмжээ 90 хувь, 25 арга хэмжээ 70 хувь, 7 арга хэмжээ 50 хувь, 10 арга хэмжээ 30 хувийн хэрэгжилттэй тус тус дүгнэгдэж, ерөнхий үнэлгээ дунджаар 72.0 хувь байна.

**Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний
хөтөлбөрийн 2020 оны үйл ажиллагаанд хийсэн
хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн**

Хүснэгт 3

д/д	Зорилт	Арга хэмжээний тоо	Үнэлгээ, хувь					Дундаж үнэлгээ	
			100	Тодорхой үр дүнд хүрсэн		Эрчимжүүлэх шаардлагатай			0
				90	70	50	30		
1	Зорилт-1	8	1	1	4	2	-	71.3	
2	Зорилт-2	14	7		4		3	76.4	
3	Зорилт-3	13	2	2	4	5		70.0	
4	Зорилт-4	16	7	1	6		2	86.9	
5	Зорилт-5	6	2		2	2	-	73.3	
6	Зорилт-6	3	1			1	1	60.0	
7	Зорилт-7	10	4		5		1	78.0	
Нийт		70	24	4	25	10	7	75.0	

Зорилт 1. “Эрчимжсэн мал аж ахуйн үйл ажиллагааг бүсчилж, төрөлжүүлэн кластер, ложистикийн сүлжээний үйлчилгээг хөгжүүлэх”-ийн хүрээнд 8 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажилласан бөгөөд 1 дүгээр зорилтын хэрэгжилтийн дундаж 68.7 хувь байна. Нийт 8 арга хэмжээнээс 100 хувь хэрэгжсэн 1 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-90 хувийн хэрэгжилттэй 5 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай буюу 50 хувийн гүйцэтгэлтэй 2 арга хэмжээ байна.

Зорилт 2. “Мал, амьтны гаралтай зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг бууруулах, экспортыг дэмжих дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах”-ийн хүрээнд 14 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажилласан бөгөөд 2 дугаар зорилтын хэрэгжилтийн дундаж 76.4 хувь байна. Нийт 14 арга хэмжээнээс 100 хувь хэрэгжсэн 7 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувийн хэрэгжилттэй 4 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай буюу 30 хувийн гүйцэтгэлтэй 3 арга хэмжээ байна.

Зорилт 3. “Гойд ашиг шимт үржлийн мал, амьтны тоог нэмэгдүүлж, хот суурингийн хүн амын хүнсний хэрэгцээний сүү, мах, өндөг, зөгийн бал болон бусад түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл хангамжийг сайжруулах”-ийн хүрээнд 13 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажилласан бөгөөд 3 дугаар зорилтын хэрэгжилтийн дундаж 70.0 хувь байна. Нийт 13 арга хэмжээнээс 100 хувь хэрэгжсэн 2 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-90 хувийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай буюу 50 хувийн гүйцэтгэлтэй 5 арга хэмжээ байна.

Зорилт 4. “Эрчимжсэн мал аж ахуйн техник, технологийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, бүтээмж үр ашгийг нь нэмэгдүүлэх”-ийн хүрээнд 16 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажилласан бөгөөд 4 дүгээр зорилтын хэрэгжилтийн дундаж 86.9 хувь байна. Нийт 16 арга хэмжээнээс 100 хувь хэрэгжсэн 7 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-90 хувийн хэрэгжилттэй 7 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай буюу 50 хувийн гүйцэтгэлтэй 2 арга хэмжээ байна.

Зорилт 5. “Боловсруулах үйлдвэрт нийлүүлэх мах, сүүний улирлын хамаарлыг бууруулах, аюулгүй байдлыг бүртгэлээр баталгаажуулах”-ийн хүрээнд 6 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажилласан бөгөөд 5 дугаар зорилтын хэрэгжилтийн дундаж 70.0 хувь байна. Нийт 6 арга хэмжээнээс 100 хувь хэрэгжсэн 2 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай буюу 50 хувийн гүйцэтгэлтэй 2 арга хэмжээ байна.

Зорилт 6. “Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн санаачлага хөрөнгө оруулалыг урт хугацааны хөнгөлөлттэй зээл, татварын бодлогоор дэмжих”-ийн хүрээнд 3 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажилласан бөгөөд 6 дугаар зорилтын хэрэгжилтийн дундаж хамгийн бага буюу 53.3 хувь байна. Нийт 3 арга хэмжээнээс 100 хувь хэрэгжсэн 1 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай буюу 30-50 хувийн гүйцэтгэлтэй 2 арга хэмжээ байна.

Зорилт 7. “Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн технологи, эдийн засгийн мэдлэгийг сайжруулах, чадавхижуулах”-ийн хүрээнд 10 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажилласан бөгөөд 7 дугаар зорилтын хэрэгжилтийн дундаж 78.0 хувь байна. Нийт 10 арга хэмжээнээс 100 хувь хэрэгжсэн 4 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувийн хэрэгжилттэй 5 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай буюу 30 хувийн гүйцэтгэлтэй 1 арга хэмжээ байна.

ДҮГНЭЛТ

1. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар 65.6 хувь, 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 75.0 хувьтай байна. Үүнээс 24 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, тодорхой үр дүнд хүрсэн 29 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай 17 арга хэмжээ байна.
2. Ковид-19 цар тахал, төсвийн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалж зарим арга хэмжээний хэрэгжилт удааширч хойшлогдсон, санхүүжилт тавигдаагүй тул 2020 оны хэрэгжилт өмнөх оноос 6.8%-иар буурсан үзүүлэлттэй байна.

ЗӨВЛӨМЖ

1. Хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг боловсруулж улсын төсөвт суулгаж ажиллахыг СХОГ, МААБХЗГазарт;
2. Аймаг, орон нутгийн мэргэжлийн байгууллага болон харьяа байгууллагын хэрэгжилтийн тайланг нэгтгэж, зохион байгуулсан арга хэмжээг улсын хэмжээнд нэгтгэн дүгнэж төсвийн эх үүсвэрийн хамт тодорхой тайлагнахыг холбогдох бүх газарт;
3. Тухайн жилийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шатанд учирч болох эрсдлийг урьдчилан тооцоолох, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэнтэй хамтран ажиллахыг холбогдох бүх газарт;

4. Тухайн жилийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэх салбарын бүх байгууллагуудад хүргүүлэх, арга хэмжээ бүрт хариуцан ажиллах байгууллага, албан тушаалтныг тусгаж ажиллахыг холбогдох бүх газарт;
5. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хөтөлбөрийн хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнаж, цахим санд баталгаажуулахыг холбогдох бүх газарт;
6. Мэдээллийн цахим санд тухайн арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг оруулж ажиллахыг ХШҮДАГ-т тус тус зөвлөмж болгож байна.

“ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

2020 оны жилийн эцэс

Д/д	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2020 оны зорилтот түвшин, ҮР дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
1.1. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг чиглэл, цар хүрээ, зорилтот зах зээл, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн түвшинтэй нь уялдуулан төрөлжүүлэн ангилах, бүсчлэл тогтоох, баталгаажуулах;						
1	1.1.1. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлд бүсчлэл тогтооно	2019 - 2022			Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 10 сарын 05-ны өдрийн А-288 дугаар тушаалыг хэрэгжүүлж "ЭМААэрхлэх бүс тогтоох тандан судалгаа хийх ажлын гүйцэтгэгчийг сонгох" тендерийг зохион байгуулсан. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс тогтоох, тандан судалгаа хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн энэ ажлын тендер шалгаруулалтад 19,302,300.00 /Арван есөн сая гурван зуун хоёр мянга гурван зуу/ төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн “Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуй биотехнологийн сургууль”-ийн ирүүлсэн тендерийг “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендерээр шалгаруулан гэрээг байгуулах эрх олгох дүгнэлтийг захиалагчид хүргүүлсэн боловч захиалагч хүчингүй болгосон. Иймд 2021 онд дахин хийхээр төлөвлөөд байна.	70%
2	1.1.2. Эрчимжсэн аж ахуйнуудыг үйл ажиллагааны чиглэлээр төрөлжүүлэн ангилна	2019 - 2022			<ol style="list-style-type: none"> Орон нутагт эрчимжсэн аж ахуйнуудыг үйл ажиллагааны чиглэлээр төрөлжүүлэн ангилах ажил хийгдэж байна. Дорнод аймаг 2018 онд ИТХ-ын 10 дугаар тогтоолоор “Мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлого”-ыг батлуулсан. Энэхүү бодлогоор Баянтүмэн, Булган, Хэрлэн, Чойбалсан, Сэргэлэн сумдын үхэр сүрэгт сүү-махны, мах-сүүний, сүүний, Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Гурванзагал, Цагаан-Овоо, Чулуунхороот сумдын үхэр сүргийг махны чиглэлийн үхэрээр сайжруулах, Хэрлэн, Баянтүмэн, Чойбалсан, Булган, Сэргэлэн сумдад бэлчээрийн болон хагас эрчимжсэн үхрийн аж ахуйг түлхүү хөгжүүлэх бодлогоор төрөлжүүлж байна. Завхан аймагт Цөм сүргийн салбар болон мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний 4 нэгжээр Эрдэнэхайрхан, Алдархаан, Цагаанхайрхан сумын 45 малчин өрхийн Сартуул үүлдрийн хонь 12543, Дөрвөлжин сумын 28 малчин өрхийн Завхан буурал үүлдрийн ямаа 6759, Тосонцэнгэл, Их-Уул сумын 59 малчин өрхийн сарлаг 3090, Тэс, Баянтэс сумын 17 малчин өрхийн адуу 502 нийт 8 сумын 149 малчин өрхийн 22894 малыг үзлэг ангилалтад хамруулж 28,8 хувь буюу 6601 малаар цөм сүрэг бүрдүүлсэн. Сартуул 270 хуцан хурга, Завхан буурал 322 ишгэн ухна шинээр тавьсан. Дөрвөлжин сумаас Завхан буурал үүлдрийн ухна ишиг Хөвсгөл аймгийн Цагаан –уул суманд 80 , өөрийн аймгийн Яруу суманд 52 , Идэр суманд 50 захиалгаар өгч, онд оруулах, үржилд зориулан бойжуулах ажил хийгдэж байна. 	70%
3	1.1.3. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх гол бүс нутгийн болон тариалангийн талбайн	2019 – 2022			Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 131 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх гол бүс нутгийн болон тариалангийн талбайн хил хязгаарыг тогтоох чиглэлээр Сэлэнгэ аймгийн 17 сумын 56 баг, Дархан-Уул аймгийн 4 сумын 14 багийн нутгийг тариалангийн бүс болгон чөлөөлөх, бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдийг нүүлгэн шилжүүлэх, соён	90%

	хил хязгаарыг тогтоох чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.				гэгээрүүлэх, мал сүргийг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө гаргах, үе шаттай хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн мэргэжлийн байгууллага, аймаг, сумдад чиглэл хүргүүлэх, дэлгэрэнгүй тоон мэдээ, судалгаа авч тариалангийн талбайн хил хязгаарыг тогтоох чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Газар тариалангийн бүс нутагт байгаа бэлчээрийн малаас авах албан татварын хэмжээг толгой тутамд 2000 төгрөг байхаар тооцох шийдвэрийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталж мөрдөх чиглэл өгсөн. Тариалангийн бүсэд хамаарах малчин болон мал бүхий өрх, хуулийн этгээд, тэдгээрийн малын төрөл, тоо, нас, хүйс, өмчлөлийн болон эзэмшлийн өвөлжөө, хаваржаа, худаг уст цэгийн тоо, малын бүлэглэлт зэргийг 2020 оны жилийн эцсийн байдлаар баг, сум, аймгаар гаргуулсан үүнд цаашид авах арга хэмжээний талаар судалгаа дүгнэлт хийж байна. Тариалангийн бүс нутагт байгаа малчид, мал аж ахуй эрхлэгчдийн нийгмийн баталгааг хангах, амьжиргааны түвшинг бууруулахгүй тухайн бүс нутгийг чөлөөлөх, харилцан өгөөжтэй байдлаар өөрчлөн зохион байгуулах боломжийг судлаж байна.	
4	1.1.5. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлд усны зохистой ашиглалт, тогтвортой хэрэглээг дэмжихэд чиглэгдсэн судалгааг хийж, тухайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	2019 – 2022	-		<ol style="list-style-type: none"> 1. Улаанбаатар хотын Багануур, Багахангай, Баянзүрх дүүргийн эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч, малчдын санаачилгаар 2020 онд худаг гаргах судалгаа, хайгуул хийж инженерийн хийцтэй 3 худаг шинээр барьж ашиглалтанд оруулсан. 2. Орхон аймагт орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3 худгийг 74.2 сая төгрөгийн хөрөнгөөр шинээр барьж ашиглалтанд оруулав. 	70%
1.2. Сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуйг нийслэл орчмын, аймгийн төвийн, тариалангийн бүсийн гэсэн гурван чиглэл, үйл ажиллагааны түвшнээр ангилж, кластер, цогцолборын зохион байгуулалтад оруулах, мэргэжлийн холбоодын үйл ажиллагаанд түшиглэн сүү бэлтгэн нийлүүлэх тогтолцооны шинэчлэлийг дэмжих, хөгжүүлэх;						
5	1.2.2. Сүүний чиглэлийн үхрийн төрөлжсөн аж ахуйг үйл ажиллагааны түвшнээр ангилах замаар цогцолборын зохион байгуулалтад оруулах	2019 - 2023			<ol style="list-style-type: none"> 1. 2020 онд Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газартай сүүний бүртгэлийн санг хөтлөх гэрээ хийж үржлийн ажил, үйлчилгээнд хамрагдсан нийт малаас сүүний чиглэлийн арвин ашиг шимтэй 1850 үнээний гарвал, ашиг шимийн мэдээлэлийг бүртгэлийг нэгдсэн санд оруулав. Сүүний чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэгч иргэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцан цаашид сүүний үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих өргөжүүлэн хөгжүүлэх борлуулалтын сувгийг нээх зохион байгуулалтын сургалт мэдээллээр 200 иргэн аж ахуй нэгжид сургалт мэдээлэл хүргэсэн. 2. Нүүдэлчин агро ферм ХХК-2019 онд Монбелиард үүлдрийн 96 толгой гунжин үнээ, 2020 онд 96 толгой гунжин үнээг Франц улсаас импортлон Төв аймгийн Аргалант, Баяндэлгэр суманд сүүний чиглэлийн үхрийн төрөлжсөн цогцолбор байгуулан ажиллаж байна. Сүүнд урамшуулал олгож байгаатай холбогдуулан аймаг сумдууд сүүний төрөлжсөн үүлдрийн цогцолборын зохион байгуулалтанд олноор орж байна. 	70%
6	1.2.3. Сүүний фермерийн стандартыг тогтоох,	2019 - 2023			2018 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн стандарчлалын үндэсний зөвлөлийн 16 дугаар тогтоолоор "Сүүний үхрийн аж ахуйд тавигдах ерөнхий шаардлага" MNS 67-23:2018 стандартыг батлан мөрдөж ажиллаж байна.	100%
1.8. Эрчимжсэн аж ахуйд сүрэг сэлбэх үржлийн гойд ашиг шимт хээлтэгч, эх сүргийг нийлүүлэх чиглэлээр дагнасан үржлийн аж ахуй эрхлэгчид олон улсын байгууллагатай хамтарсан төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;						
7	1.8.1. Эрчимжсэн аж ахуйд чиглэл тус бүрт	2019 - 2023			1. ХХААХҮСайдын 2018 оны А-145 дугаар тушаалаар баталсан "Үржлийн малд хянан магадлагаа хийх, баталгаажуулах, үүлдэрлэг байдлыг тодорхойлох, хяналт тавих журам"-ын	50%

	сүрэг сэлбэх үржлийн гойд ашиг шимт мал нийлүүлэх үржлийн аж ахуйнуудыг бий болгоно				<p>хүрээнд Булган аймгийн Бүрэгхангай суманд үржүүлж буй мах-ноосны чиглэлийн нутгийн шилмэл 15.0 мянган хонь, Төв аймгийн Батсүмбэр суманд үржүүлж буй сүү-махны чиглэлийн хосолмол ашиг шимт 23.0 мянган үхэр, Баянхонгор аймгийн Баянбулаг суманд үржүүлж буй мах-бүдүүвтэр ноосны чиглэлийн 15.2 мянган хонь, Дундговь аймгийн Хулд суманд үржүүлж буй мах-ноосны чиглэлийн 5.5 мянган тэмээнд тус тус хянан магадлагаа хийж, ажлын тайлан, дүгнэлтийг Малын генетик нөөцийн үндэсний зөвлөлдөх хороо, ХХААХҮСайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, бие даасан үүлдрийн хэсэг, үржлийн хэсэг, омгоор баталгаажуулж, 2020-2025 он хүртэл хэрэгжүүлэх үржил селекцийн ажлын хөтөлбөрийг батлав.</p> <p>2. Цөм сүргийн нийт 8902 мянган толгой малыг үзлэг ангилалтад хамруулж, үүнээс элит, 1 болон 2-р ангийн 7252 малыг ялган бүртгэлжүүлж, тухайн үүлдрийн малын жишигт тэнцэхгүй болон насаар 1650 толгой малыг заазлан зах зээлд худалдан борлуулж төсвийн дансанд төвлөрүүлж ажиллав.</p> <p>3. Увс аймгийн цөм сүргийн салбар нэгжээс НҮБ-ын ХХААБ-аас хэрэгжүүлж байгаа төсөлд Баяд үүлдрийн 12 хуц, Архангай аймгийн Өлзийт суманд 12 хуц тус тус үржилд зориулан худалдаж, шинээр хурган хуц 74 толгой, ухна ишиг 1 толгойг сонгон тавьж, Завхан аймгийн цөм сүргийн салбар нэгжээс НҮБ-ын ХХААБ-аас хэрэгжүүлж байгаа төсөлд Сартуул үүлдрийн 18 хуц худалдаж, 105 хурган хуц сонгон тавьж, Сүхбаатар аймгийн цөм сүргийн салбар нэгжээс Үзэмчин үүлдрийн 6 хуц, Баяндэлгэрийн улаан үүлдрийн 4 ухна зах зээлд худалдаж, шинээр 32 хурган хуц, 14 ухна ишиг сонгон тавив. Орон нутгийн цөм сүргийн салбар нэгжийн малаас нийт жишигт тэнцсэн 241 толгой хээлтүүлэгчийг иргэд, аж ахуйн нэгжүүдэд худалдан борлуулж, 297-н толгой өсвөр хээлтүүлэгчийг үржилд зориулан сонгон тавив.</p>	
1.9. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид бэлчээр, хадлангийн газар, таримал тэжээл тариалах тариалангийн талбайг гэрээгээр ашиглуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх, хэрэгжилтийг хангах.						
8	1.9.2. Бэлчээр дэх өвс, ургамлын бүтэц, тархац, ургац, ус, тэжээлийн нөөцийн урьдчилсан судалгааг хийж, эрчимжсэн мал аж ахуй, түүнд суурилсан үйлдвэрлэлийг бүсчилсэн, эсхүл хэсэгчилсэн хэлбэрээр хөгжүүлэх чиглэл, бүсийг тогтооно.	2019 – 2020	-		<p>1. Архангай аймгийн Тамрын итгэл хоршоо болон олон улсын төсөл хөтөлбөрүүдтэй хамтран малын тэжээл тариалах тэжээлийн ургамлыг хадгалах технологи, өрхийн нөхцөлд халгай лууль малын яс зэрэг бусад ургамлыг ашиглан дарш хийх, технолги болон мал тэжээх арга туршлагын талаар 130 гаруй малчинд сургалт явууллаа. Үржлийн малд зориулсан 5 төрлийн уурагт холимог тэжээлийг үйлдвэрлэж байна.</p> <p>2. 2020 онд бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 21 аймгийн 193 сумдад улсын төсвийн 1.67 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 83, гадаадын төсөл, хөтөлбөрийн 3.7 тэрбум төгрөгөөр 180, орон нутгийн төсвийн 3.7 тэрбум төгрөгөөр 287 инженерийн хийцтэй худаг, малчдын өөрсдийн санаачлагаар 170 гар худаг, нийт 9.0 тэрбум төгрөгөөр 550 инженерийн хийцтэй худаг гаргасан нь 825.0 мянган га бэлчээр, 2.7 мянган малчин өрхийн 1.5 сая толгой малын усан хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ болсон.</p> <p>3. "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт" төслийн санхүүжилтээр "Говь-Алтай, Булган, Дундговь, Ховд, Завхан, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Сүхбаатар, Хэнтий аймаг, отрын бүс нутагт инженерийн хийцтэй 61 худаг барих ажил гүйцэтгэхээр 3 удаа нээлттэй тендер шалгаруулалт явуулсан. Дундговь, Ховд, Завхан, Архангай, Баянхонгор, Сүхбаатар, Хэнтий аймгууд инженерийн хийцтэй 46 худаг шинээр</p>	50%

					гаргаж ашиглалтанд оруулснаар 129 мянган мал сүргийг усаар хангах боломжтой болов. Харин Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Говьсүмбэр, Булган аймгийн ажил бүрэн дуусаагүй тул АХБ-тай зөвөлдсөний дагуу ажил гүйцэтгэх гэрээний хугацааг 2021 оны 05 сар хүртэл сунгаж гэрээнд өөрчлөлт оруулав. “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн нэмэлт санхүүжилт” төслөөр Архангай, Өвөрхангай, Дундговь, Сүхбаатар, Дорнод, Хэнтий аймгуудад 157 худаг шинээр гаргахаас 143 худаг, сэргээгдэх эрчим хүчээр ажиллах 2 худгийн ажил бүрэн дуусч ашиглалтанд оруулсанаар 400 мянга гаруй мал сүргийг усаар хангах боломжийг бүрдүүлэв.	
2.1. Шингэн сүү, сүүн бүтээгдэхүүн, үхрийн хөлдүү мах, өндөг, гахай, шувууны мах, өөх, зөгийн балны импортыг үе шаттайгаар бууруулах, зарим нэр төрлийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг мэргэжлийн холбоодтой хамтран төлөвлөж, хэрэгжүүлэх;						
9	2.1.1. Шингэн сүү, сүүн бүтээгдэхүүнийг импортыг бууруулах төлөвлөгөөг баталж хэрэгжүүлнэ.	2019 - 2023	-		<ol style="list-style-type: none"> 1. Сүүний хангамж нэмэгдэж байгаа боловч сүүлийн 5 жилийн дунджаар авч үзвэл, хэрэгцээт сүүний 85 хувийг уламжлалт аргаар, 15 хувийг үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүгээр хангаж байна. Энэ нь үйлдвэрт зөвхөн эрчимжсэн аж ахуйгаас үнээний сүү нийлүүлж, үлдсэн малын сүүг уламжлалт цагаан идээ бэлтгэх, тухайн орон нутгийн хүн амын ундны сүүний хэрэгцээг хангахад зарцуулж байгаатай холбоотой юм. Эрчимжсэн аж ахуйгаас нийлүүлэх сүүний хэмжээ нийт нийлүүлэлтийн 84.3 хувийг бүрдүүлж байгаа боловч зөвхөн улирлын чанартай байгаа тул өвөл, хаврын улиралд төвлөрсөн хот, суурин газрын хүн амын сүүний хэрэгцээг бүрэн хангах нөхцөл, боломж бүрдэхгүй байна. 2. Сүүний чиглэлийн цэвэр үүлдрийн 3.3 мянган үнээ, харин эрлийз 67 мянган үнээ байгаа ба сүүний гарцын хувьд цэвэр үүлдрийн үнээнээс өдөрт 18 литр, эрлийз үнээнээс 6 литр сүү сааж байна. Эрчимжсэн мал аж ахуйгаас өвөл, хаврын улиралд төвлөрсөн хот, суурин газрын хүн амын хэрэгцээг дотоодын сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах боломж бүрдэхгүй байгаа тул хуурай сүү импортлон үйлдвэрлэлд ашиглаж байна. 3. Сүү бэлтгэн нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх, хуурай сүүний импортыг үе шаттай бууруулах, сүү, сүүн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэхэд сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох журмыг боловсруулж ЗГ-ын 130 дугаар тогтоолоор батлуулсан. Журамд заасан шаардлага хангасан сүү боловсруулах 8 үйлдвэрт 11 дүгээр сард 1,939,944.0 литр техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү бэлтгэн нийлүүлсэн Үндэсний статистикийн хорооны 2019 оны мал тооллогын А дансны бүртгэлтэй, сүүний үйлдвэрт нийлүүлсэн сүүгээ сүүний үйлдвэрт нийлүүлсэн сүүгээ и-баримтад бүртгүүлэн баталгаажуулсан 2375 малчин, эрчимжсэн мал аж ахуйн эрхлэгчдэд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А-387 дугаар тушаалын дагуу 969,972,000.0 төгрөгийн урамшуулал олгосон. 	100%
10	2.1.2. Эрчимжсэн үхрийн аж ахуйн махны экспортыг нэмэгдүүлэх, үхрийн хөлдүү махны импортыг бууруулах	2019 - 2023	-		Стратегийн хүнсний экспорт, импорт гаалийн гүйцэтгэлээр /2020 оны 12 дүгээр сарын 03-ны байдлаар/ адууны мах 17.6 мянган тн, дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны мах 17.7 мянган тн, хонины түүхий мах 1.1 мянган тн, нийт 36.4 мянган тн махны экспорт тус тус хийгдсэн байна. Мах, махан бүтээгдэхүүн экспортлох ажил үргэлжилж байна.	70%

	төлөвлөгөөг баталж хэрэгжүүлнэ.					
11	2.1.3. Шувууны мах, өндөгний импортыг бууруулах төлөвлөгөөг баталж хэрэгжүүлнэ.	2019 - 2023	-		2020 оны эхний 11 сарын байдлаар 14388,6 тн шувууны мах, 158,044 мян, ширхэг өндөг импортлогдсон дүнтэй байна. Шувууны мах болон өндөгний дотоодын үйлдвэрлэлийн тоо хэмжээ 2020 оны жилийн эцсээр гарах тул тооцоолол хийх боломжгүй байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар шувууны махны 3,4 хувь, өндгийг 52,6 хувийг дотоодын үйлдвэрлэлээс хангасан байна.	30%
12	2.1.4. Гахайн мах, өөхний импортыг бууруулах төлөвлөгөөг баталж хэрэгжүүлнэ.	2019 - 2023	-		2020 оны 11 сарын импортын гүйцэтгэлээр 3323,2 тн гахайн мах, 2458,1 тн өөх импортлосон байна.	30%
13	2.1.5. Зөгийн балны импортыг бууруулах, экспортыг нэмэгдүүлэх төлөвлөгөөг баталж хэрэгжүүлнэ.	2019 - 2023	-		Зөгийн балны үлдэгдлийг хянах төлөвлөгөөг Европын холбооны бусад улс орнуудад тавих шаардлагын дагуу боловсруулан ЕХ-ны Хүнсний аюулгүй байдлын газарт хүргүүлж, зөгийн баланд малын эмийн болон пестицидийн үлдэгдлийг тодорхойлох лаборторийн хүчин чадлыг бэхжүүлэх талаар ажиллаж байна.	30%
14	2.1.6. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиг хандлагын судалгааг хийнэ.	2019 - 2020			Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 10 сарын 05-ны өдрийн А-288 дугаар тушаалыг хэрэгжүүлж "ЭМААэрхлэх бүс тогтоох тандан судалгаа хийх ажлын гүйцэтгэгчийг сонгох" тендерийг зохион байгуулсан. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс тогтоох, тандан судалгаа хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн энэ ажлын тендер шалгаруулалтад 19,302,300.00 /Арван есөн сая гурван зуун хоёр мянга гурван зуу/ төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн "Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуй биотехнологийн сургууль"-ийн ирүүлсэн тендерийг "Хамгийн сайн" үнэлэгдсэн тендерээр шалгаруулан гэрээг байгуулах эрх олгох дүгнэлтийг захиалагчид хүргүүлсэн боловч Захиалагч хүчингүй болгосон. Энэ судлагааг эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиг хандлагын судалгааг хийхээр төлөвлөж ажлын даалгавар хийсэн байсан боловч захиалагч зогсоосон тул 2021 онд дахин хийхээр төлөвлөдөг байна.	70%
2.2. Сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэл, технологийн түвшинг сайжруулан, гойд ашиг шимт үхрийн тоог нэмэгдүүлэх, зохиомол хээлтүүлгийн цар хүрээг тэлэх арга хэмжээг хэрэгжүүлж, дотоодын шингэн сүүний үйлдвэрлэл, боловсруулалтыг өсгөх, импортын шингэн болон шар сүүг 100 хувиар халж, цөцгийн тос, аарц тараг зэрэг сүүн бүтээгдэхүүний импортыг 30 хүртэл хувиар бууруулах;						
15	2.2.1. Сүүний эрчимжсэн одоо ажиллаж байгаа аж ахуйнуудыг холдинг компанид нэгдэн хөгжихийг дэмжих замаар дотоодын сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ	2019 - 2023			Сүү ХК санаачлан НҮБ-ын ХХААБ-ын санхүүжилтээр сүү бэлтгэн нийлүүлэгчдийг хоршоожуулах, хоршоо бүрийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, сүүний чанарыг сайжруулах, хөдөө аж ахуйн зохистой дадлыг хоршооны оролцогч бүр фермдээ нэвтрүүлэх, үйлдвэрт чанартай сүү нийлүүлэх зорилгоор орчин цагийн сүү бэлтгэн нийлүүлэлтийн анхны загвар хоршоог Сонгинохайрхан дүүргийн Ар гүнтийн аманд байгуулсан. Үйл ажиллагаанд 30 гаруй иргэн, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч оролцож сүү бэлтгэн нийлүүлэлт, сүүний чанар, сүүний гарцын талаар санал солилцсон. Эдгээр хоршоо нь өнгөрсөн онд 20.2 сая.литр түүхий сүү үйлдвэрт тушаасан. 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн Засгийн газрын 130 дугаар тогтоолоор Сүүний урамшуулал олгох журмыг баталсан. Журамд заасан шаардлага хангасан сүү боловсруулах 8 үйлдвэрт 2020 оны 11 дүгээр сард 1,939,944.0 литр шаардлагад нийцсэн малын түүхий сүү бэлтгэн нийлүүлж сүүний үйлдвэрлэлийн хэмжээ 11%-иар нэмэгдсэн байна.	100%

16	2.2.2. Хуурай сүүний импортын татварыг боломжит дээд хэмжээнд хүргэж нэмэгдүүлж тогтооно	2019 - 2023		Эрчимжсэн аж ахуйгаас нийлүүлэх сүүний хэмжээ нийт нийлүүлэлтийн 84.3 хувийг бүрдүүлж байгаа боловч зөвхөн улирлын чанартай байгаа тул өвөл, хаврын улиралд төвлөрсөн хот, суурин газрын хүн амын сүүний хэрэгцээг бүрэн хангах нөхцөл, боломж бүрдэхгүй байна. Эрчимжсэн аж ахуйгаас нийлүүлэх нийт сүүний хэмжээ сэрүүний улиралд 35%, дулааны улиралд 65%-ийг бүрдүүлж байна. Хот суурин газрын хүн амын хэрэгцээг шингэн сүүгээр хангаж чадахгүй байгаа тул дотоодын аж ахуйн нэгжүүд хуурай сүү импортлон үйлдвэрлэлдээ ашиглаж байна. Өвөл, хаврын улиралд хот, суурин газрын хүн амын 85 хүртэл хувь нь импортын хуурай сүү сэргээж үйлдвэрлэсэн шингэн сүү хэрэглэж байна.	70%
17	2.2.3. Шингэн сүү, сүүн бүтээгдэхүүний импортын хэмжээг бууруулна.	2019 - 2023		Эрчимжсэн мал аж ахуйгаас өвөл, хаврын улиралд төвлөрсөн хот, суурин газрын хүн амын хэрэгцээг дотоодын сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах боломж бүрдэхгүй байгаа тул хуурай сүү импортлон үйлдвэрлэлд ашиглаж байна. Сүү бэлтгэн нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх, хуурай сүүний импортыг үе шаттай бууруулах, сүү, сүүн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэхэд сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох журмыг боловсруулж ЗГ-ын 130 дугаар тогтоолоор батлуулсан. Журамд заасан шаардлага хангасан сүү боловсруулах 8 үйлдвэрт 11 дүгээр сард 1,939,944.0 литр техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү бэлтгэн нийлүүлсэн Үндэсний статистикийн хорооны 2019 оны мал тооллогын А дансны бүртгэлтэй, сүүний үйлдвэрт нийлүүлсэн сүүгээ сүүний үйлдвэрт нийлүүлсэн сүүгээ и-баримтад бүртгүүлэн баталгаажуулсан 2375 малчин, эрчимжсэн мал аж ахуйн эрхлэгчдэд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А-387 дугаар тушаалын дагуу 969,972,000.0 төгрөгийн урамшуулал олгосон. Иймд одоогоор импортын татварыг нэмэгдүүлэх боломж бүрдэхгүй байна.	100%
18	2.2.4. Сүү, сүүн бүтээгдэхүүний импортыг бууруулна.	2019 - 2023		Эрчимжсэн мал аж ахуйгаас өвөл, хаврын улиралд төвлөрсөн хот, суурин газрын хүн амын хэрэгцээг дотоодын сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах боломж бүрдэхгүй байгаа тул хуурай сүү импортлон үйлдвэрлэлд ашиглаж байна. Сүү бэлтгэн нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх, хуурай сүүний импортыг үе шаттай бууруулах, сүү, сүүн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэхэд сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох журмыг боловсруулж ЗГ-ын 130 дугаар тогтоолоор батлуулсан. Журамд заасан шаардлага хангасан сүү боловсруулах 8 үйлдвэрт 11 дүгээр сард 1,939,944.0 литр техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү бэлтгэн нийлүүлсэн Үндэсний статистикийн хорооны 2019 оны мал тооллогын А дансны бүртгэлтэй, сүүний үйлдвэрт нийлүүлсэн сүүгээ сүүний үйлдвэрт нийлүүлсэн сүүгээ и-баримтад бүртгүүлэн баталгаажуулсан 2375 малчин, эрчимжсэн мал аж ахуйн эрхлэгчдэд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А-387 дугаар тушаалын дагуу 969,972,000.0 төгрөгийн урамшуулал олгосон. Иймд одоогоор импортын татварыг нэмэгдүүлэх боломж бүрдэхгүй байна.	100%
2.3. Махны чиглэлийн үхэр, хонины аж ахуйн технологийн эрчимжүүлэлтийг дэмжиж, махны экспортын бодлогод нийцүүлэн мал бордох үр ашигтай аргачлал, технологийг нэвтрүүлж мах үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, үхрийн хөлдүү махны импортыг бүрэн халж, махны экспортыг 30,0 хувиар нэмэгдүүлэх;					
19	2.3.3. Үхрийн хөлдүү махны импортыг	2019 - 2023		Стратегийн хүнсний экспортын гүйцэтгэлээр /2020 оны 12 дүгээр сарын 03-ны байдлаар/ адууны мах 17.6 мянган тн, дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны мах 17.7 мянган тн, хонины түүхий	70%

	бууруулж, экспортыг нэмэгдүүлнэ				мах 1.1 мянган тн, нийт 36.4 мянган тн махны экспорт тус тус хийгдсэн байна. Мах, махан бүтээгдэхүн экспортлох ажил үргэлжилж байна.	
2.4. Шувууны аж ахуйн технологийн түвшин, эрчимжүүлэлтийг сайжруулах, сүрэг сэлбэх хэрэгцээнд дэгдээхэй нийлүүлэх үржлийн аж ахуйд бодлогын дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн холбоодын үйл ажиллагаанд түшиглэн шувууны мах, өндөг үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортын өндгийг 90 хувь, шувууны махыг 30 хувиар бууруулах;						
20	2.4.1. Шувууны аж ахуйн технологийн түвшин, эрчимжүүлэлтийг дэмжиж, шувууны мах, өндөг үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	2019 - 2023			Шувууны аж ахуй эрхлэгч аж ахуйн нэгжүүд 2020 онд 173 сая ширхэг өндөг үйлдвэрлэж, нийт хэрэгцээт өндөгний 53%-ийг дотооддоо үйлдвэрлэлээ. Түмэн шувуут ХХК Бүгд найрамдах Болгар улсын “Dion Engineering” компаниас бүрэн автомат, европ стандартын тоног төхөөрөмжийг авч угсран Шингэн өндөгний үйлдвэрийг ашиглалтанд оруулан шингэн өндөгний үйлдвэрлэлийг эхлүүлж 10, 20 кг-ийн савлагаатай зах зээлд гаргалаа.	100%
2.6. Зөгийн аж ахуйн зохион байгуулалт, үйлдвэрлэлийн технологийн түвшин, зөгийчдийн мэдлэг, ур чадварыг сайжруулан дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах ажлыг мэргэжлийн холбоотой хамтран гүйцэтгэж, зорилтот зах зээлд бэлтгэн нийлүүлэх зөгийн бал, бусад дагалдах бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлэн, импортын зөгийн балыг 70 хувиар бууруулах;						
21	2.6.1. Зөгийн аж ахуйн зохион байгуулалтыг сайжруулна	2019 - 2023			<ol style="list-style-type: none"> 1. ЗААМЭҮЭАНЗаавар батлагдсан. Дагалдан дараахь бичиг баримтууд хавсарган гарсан: - Зөгийчин, зөгийн аж ахуй эрхлэгч ба орон нутгийн мал эмнэлгийн хооронд хийх гэрээний жишиг загвар - Зөгийн эрүүл мэнд, эрүүл ахуй, зөгийн балны гарал үүслийн бүртгэлийн дэвтэр - Зөгийн эрүүл мэндийн тандах үзлэгийн хуудас - Зөгийн аж ахуйн мал эмнэлгийн гэрчилгээний загвар Зааврын танилцуулга, хэлэлцүүлгийг МЭАЦТЛабораторийн ахлах шинжээчийн хамт Дорнод аймгийн МЭГ-ийн ажилтнууд, малын эмч нар болон зөгийчдийн дунд явуулсан. 2. ЖАЙКА байгууллагаас хэрэгжүүлж байгаа ЖАЙКАФ /Японы ой ХАА-н ОУ-ын хамтын ажиллагааны байгууллага/-ын төслийн сургагч ба ХААҮШУОНТ, Булган, Хөвсгөл, Дорнод аймгийн ХХААГ, аймгийн салбар зөгийчдийн холбоодтой хамтран Дархан-Уул аймгийн 45, Булган аймгийн 40, Хөвсгөл аймгийн 70, Дорнод аймгийн 43, Хэнтий аймгийн 52, Ховд аймгийн 47 нийт 297 зөгийчинд технологи шинэчлэлийн сургалт явуулж дадлага хийсэн. Бие даан ЗАА-н гүнзгийрүүлсэн мэргэжлийн сургалт явуулж Хэнтий, Булган аймгийн 68 иргэнд “Зөгийчин, Зөгийн аж ахуй эрхлэгч” мэргэжлийн чадамжийн гэрчилгээ олгосон. 3. Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газар нутгийн байгалийн нөөцийн ашиглалт хамгаалалт, нөхөн сэргээлтийг сайжруулах зорилгоор байгаль хамгаалагч нарыг зөгийн аж ахуй эрхлэх сургалтанд хамруулж, Хангал нуурын судалгааны төв дээр зөгийн суурьтай болсон байна. Хөл хорионы халдвар хамгааллын дэглэмийн хугацаанд зөгийн аж ахуйн технологийн заавар нийт 15 цуврал хичээлийг фэйсбуук дээр онлайнгаар явуулж зөгийчдийг сургалтанд хамрууллаа. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан А/281, А170 -р тушаалаар “Зөгийн аж ахуйд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ийг батлуулан мөрдүүлэн ажиллаж байна. Дээрх зүрэм, заавар, стандартууд 2021 оноос зөгийчдөд танилцуулагдаж мөрдөгдөнө /халдвар хамгааллын дэглэмийн хөл хорио тавигдсаны дараа/. 	100%
22	2.6.3. Зөгийчдийн мэдлэг, ур чадварыг сайжруулах	2019 - 2023			<ol style="list-style-type: none"> 1. ЖАЙКА байгууллагаас хэрэгжүүлж байгаа ЖАЙКАФ /Японы ой ХАА-н ОУ-ын хамтын ажиллагааны байгууллага/-ын төслийн сургагч ба ХААҮШУОНТ-тэй хамтран Булган, Хөвсгөл, Дорнод аймгийн ХХААГ, аймгийн салбар зөгийчдийн холбоодтой хамтран Дархан-Уул аймгийн 45, Булган аймгийн 40, Хөвсгөл аймгийн 70, Дорнод аймгийн 43, 	100%

					<p>Хэнтий аймгийн 52, Ховд аймгийн 47 нийт 297 зөгийчинд технологи шинэчлэлийн сургалт явуулж дадлага хийсэн. Бие даан ЗАА-н гүнзгийрүүлсэн мэргэжлийн сургалт явуулж Хэнтий, Булган аймгийн 68 иргэнд “Зөгийчин, Зөгийн аж ахуй эрхлэгч” мэргэжлийн чадамжийн гэрчилгээ олгосон.</p> <p>2. Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газар нутгийн байгалийн нөөцийн ашиглалт хамгаалалт, нөхөн сэргээлтийг сайжруулах зорилгоор байгаль хамгаалагч нарыг зөгийн аж ахуй эрхлэх сургалтанд хамруулж, Хангал нуурын судалгааны төв дээр зөгийн суурьтай болсон байна. Хөл хорионы халдвар хамгааллын дэглэмийн хугацаанд зөгийн аж ахуйн технологийн заавар нийт 15 цуврал хичээлийг фэйсбуук дээр онлайнгаар явуулж зөгийчдийг сургалтанд хамрууллаа.</p>	
3.1. Сүүний чиглэлийн цэвэр үүлдрийн 3600 хээлтэй гунж, хосолмол ашиг шимт 2200 хээлтэй гунжийг импортлон нутагшуулах, тэдгээрийн үр төлд удам зүйн үнэлгээ хийх, бүртгэлжүүлэх арга хэмжээг мэргэжлийн байгуулага, холбоодын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж, сүүний үхрийн аж ахуйн эрчимжүүлэлт, кластерыг хөгжүүлэх						
23	3.1.2. Сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй, тэдгээрт үржүүлж байгаа үхэр сүргийг бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд хамруулна.	2019 - 2023			<p>ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 10 дугаар сарын 26 ны өдрийн А/329 дугаар тушаалаар байгуулагдсан 2 ажлын хэсэгт 11 мэргэжилтэн 2020 оны 10 дугаар сарын 28 наас 10 дугаар сарын 31-ны өдрийг дуустал 4 хоногийн хугацаатай Улаанбаатар, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Хэнтий, Орхон аймгуудын зарим сумдаар явж нэг суманд 3-аас доошгүй фермийн үнээнд хяналтын саам хийлээ. Ажлын хэсэг тухайн сонгогдсон сумын 3 аас доошгүй /том, жижиг, дунд/ фермерыг сонгон нийт цэвэр Хар тарлан үүлдрийн 199, Швицийн бор үүлдрийн 52, Буган халиун үүлдрийн хэсгийн 20, Алатау үүлдрийн 343 үнээ, эрлийз 131 үнээ, Нутагшсан 41 үнээнд өглөө, оройн саалинд хяналт хийж цэвэр, эрлийз, нутагшсан малаар ангилан сүүний гарцыг тодорхойлов. Мөн эрчимжсэн бүс нутгийн 488 малчин өрхийн 6278 үнээг ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулсан байна.</p>	50%
3.2. Махны чиглэлийн үхэр, хонины аж ахуйд махны хэмжээ, гарцыг нэмэгдүүлэх үржил селекцийн ажлыг явуулж, гадаадаас авчирсан махны чиглэлийн гойд ашиг шимт үхэр, хонины тэжээллэг, арчилгаа, маллагааны технологийг мөрдүүлж, удам зүйн үнэлгээгээр шалгарсан үржлийн өсвөр бухыг бойжуулах, зохиомол хээлтүүлгийн үйлчилгээний хамрах хүрээг тэлэх, бүсчлэлийн бодлогоор махны чиглэлийн үхэр, хонины аж ахуйн эрчимжүүлэлт, кластерыг дэмжин хөгжүүлэх;						
24	3.2.2. Удам зүйн үнэлгээгээр шалгарсан махны чиглэлийн үржлийн өсвөр бух, хуцыг бойжуулах, зохиомол хээлтүүлгийн үйлчилгээ үзүүлэгчдийг дэмжинэ.	2019 - 2023			<p>Зохиомол хээлтүүлгийн ажил үйлчилгээнд зориулж Улаанбаатар хотын СХД, Хан-Уул, Баянзүрх дүүрэг, Төв, Дорнод, Өвөрхангай, Дархан- Уул, Сэлэнгэ, Орхон, Архангай, Хэнтий, Төв, Завхан аймгийн 24 суманд нийт 32 мал үржүүлгийн техникчтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. Гэрээт мал үржүүлгийн техникчдийн захиалгын дагуу стандартын шаардлага хангасан Хосолмол ашиг шимт бухны 4231, сүүний чиглэлийн бухны 1007, махны чиглэлийн бухны 1182, хуц, ухны 1150 тун, нийт 7570 тун гүн хөлдөөсөн үрийг хөнгөлттэй үнээр генийн сангаас олгов. Шингэн азотын үйлдвэрт нийт 3571 литр азот үйлдвэрлэж, генийн санд 2375.5 л, үр үйлдвэрлэлд 670 л, гэрээт техникч нарт 251.5, иргэн аж ахуйн нэгжийн захиалгаар 310 литр шингэн азотыг хувиарлан олгов.</p>	50%
25	3.2.3. Махны чиглэлийн үхэр, хонины аж ахуйн хамрах хүрээг бүсчлэлийн бодлогоор тэлж, эрчимжүүлэлт, кластерыг хөгжүүлнэ.	2019 - 2023			<p>1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын “Үржлийн малд үзлэг ангилалт хийх, баталгаажуулах ажлын төсвийн хуваарь батлах тухай” 2020 оны А/112 дугаар тушаал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын “Үржлийн малд үзлэг ангилалт хийх, баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэх, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлын удирдамж”-ийн дагуу аймгууд хийснийг үндэслэн махны чиглэлийн үхэр, хонины аж ахуйн хамрах хүрээг эрчимжүүлэлт чиглэлээр төлөвлөгөө боловсруулж байна.</p>	50%

					<p>2. 2020 оны 11 дүгээр сард Франц улсаас Нүүдэлчин ХХК өөрийн хөрөнгөөр мөн 96 монбильрд гунжийг импортлон кластер фермээ өргөгтөхөд мэргэжил арга зүйн тулалцаа үзүүлэв. Махны чиглэлийн үхэр, хонины аж ахуй эрхлэгч 206 иргэн аж ахуйн нэгжийн төлөөлөлд мэргэжил арга зүйн зөвлөгөө 12 аж ахуйн нэгжийн фермтэй танилцан зааварчилгаа өгсөн байна.</p> <p>3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А-352 дугаар тушаалаар эрчимжсэн мал аж ахуйг үйл ажиллагааны чиглэлээр нь төрөлжүүлэн ангилах, бүсчлэл тогтоох, гойд ашигт шимт малын үзэсгэлэн худалдааг орон нутагт зохион байгуулах 319,0 сая төгрөгийн санхүүжилтийг хувиарлан аймгуудын ХХААГ-г хүргүүлэв.</p> <p>4. Нэгж малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх чиглэлээр Малын удмын сангийн үндэсний төв, ХХААГазартай байгуулсан гурвалсан гэрээний дагуу явуулын болон дундын 8 зохиомол хээлтүүлгийн техникч ажлууллав. Эрдэнэ сумын “Чих булаг” ХХК тал хээрийн 3 суманд 32 үхэр, 100 хонинд гардан хээлтүүлэг хийж, үржил селекцийн ажлыг явуулсан. Улсын төсвийн хөрөнгөөр Мал үржлийн алба бод, богийн зохиомол хээлтүүлгийн набор, үржлийн багаж, тоног төхөөрөмжөөр хангагдаад байна. аймгууд өөр өөрийн чиглэлээр ажлуудыг хийж байна. Жишээлбэл: БХ аймаг Монгол үхрийн амьдын жинг нэмэгдүүлэх зорилгоор Сэлэнгэ үүлдрийн дорнод талын махны хэвшлийн бухыг сайжруулагчаар ашиглаж байна Монгол хонины ашиг шимийн стандарттай харьцуулан судалгааны түвшинг гаргахад Баянбулаг омгийн хонины амьдын жин 3-5 кг-аар илүү байгаа ба Баянбулаг омгийн хонийг аймгийн хэмжээнд сайжруулагчаар ашиглаж байна.</p>	
<p>3.3. Өндөгний болон махны чиглэлийн тухайлсан үүлдрийн үржлийн 20,0 мянган өндгийг импортлох, хоногийн настай дэгдээхэйг бойжуулж аж ахуйн нэгжүүдийн сүрэг сэлбэх хэрэгцээнд нийлүүлэх үржлийн аж ахуйг бий болгох, өндөгний чанар, баталгаажуулалт, импортын өндөгний хяналтыг сайжруулах чиглэлээр мэргэжлийн байгууллага, холбоод хамтын ажиллагааг нягтруулж, үржлийн аж ахуй, мал эмнэлгийн үйлчилгээ, тэжээл бэлтгэн нийлүүлэх сүлжээ бүхий шувууны аж ахуйн эрчимжүүлэлт, кластерыг дэмжин хөгжүүлэх;</p>						
26	3.3.1. Бодлогын түвшинд цэвэр үүлдрийн тахианы үржлийн өндөг импортлоно.	2019 - 2023			<p>Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн 4.3.3-д өндөгний болон махны чиглэлийн тухайлсан үүлдрийн үржлийн 20,0 мянган өндгийг импортлох, хоногийн настай дэгдээхэй бойжуулах, аж ахуйн нэгжүүдийг сүрэг сэлбэхэд дэмжлэх үзүүлнэ гэсний заалтын дагуу 2020 онд Түмэн шувуут ХХК БНХАУ-с үржлийн 600 мянган өндгийг импортлон өөрийн аж ахуй инкуботорт даран дэгдээхэй болгон хэрэгцээнд сүрэг сэлбэсэн байна. Энэ үржлийн өндөг нь 75 хувийн бойжилттой байсан. 1 өндгийг 1000 төгрөгөөр худалдан авсан байна. Мөн махны тахианы аж ахуй эрхлэгч Ажгина ХХК үржлийн өндөг импортолсон байна. Төсвийн хүндэрлээс үүдэн төрөөс санхүүжилт өгч чадаагүй. Дээрхи аж ахуйнуудад төрөөс тусгай зөвшөөрөл олгох болон мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэн ажиллав.</p>	90%
27	3.3.2. Хоногийн настай дэгдээхэйг бойжуулах, нийлүүлэх үржлийн аж ахуйг бий болгоно	2019 - 2023			<p>Өөрийн аж ахуйн хөрөнгө оруулалтаар Түмэн шувуут ХХК 2020 онд СХД-ийн 21-р хороо, Их булаг дахь шинэ аж ахуй анхны 40,000 дэгдээхийгээ хүлээн авч үйл ажиллагаагаа эхлүүллээ. Тухайлсан үүлдрийн үржлийн 20,0 мянган өндгийг импортлох, хоногийн настай дэгдээхэйг бойжуулж аж ахуйн нэгжүүдийн сүрэг сэлбэх хэрэгцээнд нийлүүлэх үржлийн аж ахуйг бий болгох талаар ЭМААХДҮхөтөлбөрт тусгагдсан байгаа хугацаа болоогүй байна.</p>	70%
28	3.3.5. Шувуунд зориулсан тэжээл үйлдвэрлэлийг	2019 - 2023			<p>Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хороонд дэвшилтэд малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор техник, тоног төхөөрөмж бүхий сард 5000 тонн бүрэн найрлагат хорголжин болон, багсармал бүх төрлийн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай бүрэн автомат тэжээлийн</p>	70%

	нэмэгдүүлж, импортын шувууны тэжээлийг бууруулна.				үйлдвэрийг шинээр ашиглалтад оруулсан. Бүрэн автомат үйлдвэр нь дотроо нэмэлтээр премиксийн үйлдвэр, тос шахах үйлдвэр, өвс бутлах, хорголжлох үйлдвэрүүд багтсан. Монголд анх удаа премиксийн үйлдвэрийг бий болгосон байна.	
3.4. Цэвэр үүлдрийн 1000 мэгж, 50 бодонг Европын Европын бүсээс импортлон гахайн аж ахуйд үржлийн шинэ хөтөлбөр хэрэгжүүлэн өсвөр хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулж аж ахуйн нэгжүүдийн сүрэг сэлбэх хэрэгцээг хангах, зохиомол хээлтүүлгийн явуулын үйлчилгээ үзүүлэх, бүртгэлжүүлэх арга хэмжээг мэргэжлийн байгуулага, холбоод хамтран хэрэгжүүлэхийг дэмжиж, үржлийн аж ахуй, мал эмнэлгийн үйлчилгээ, тэжээл бэлтгэн нийлүүлэх сүлжээ бүхий гахайн аж ахуйн эрчимжүүлэлт, кластерыг дэмжин хөгжүүлэх;						
29	3.4.1. Бодлогын түвшинд Европын бүсээс цэвэр үүлдрийн үржлийн гахайг импортлоно.	2019 - 2023			“Зургаан хошуу” ХХК Дани улсаас цэвэр үүлдрийн 1000 мэгж, 50 бодон худалдан авах гэрээ байгуулж санхүүжилт дутагдсанаас манай яаманд 2.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл хүссэн төсөл боловсруулж ирүүлснийг дэмжиж санхүүжилт олгох талаар санал боловсруулж байна. Уг аж ахуйн нэгж нь фермээ Дани улсын технологиор засварлан гахай хүлээн авах байрыг засварлахад 1.5 тэрбум төгрөгийн хувийн хөрөнгө оруулалтаараа хийсэн. Гахай худалдан авах санхүүжилт шийдэгдсэн нөхцөлд манай орны гахайн аж ахуйн үйл ажиллагаагаа хэвийн явуулах бүрэн боломжтой болох юм.	50%
3.5. Өндөр ашиг шимт, баталгаажсан зөгийн үүлдрийн 2000 бүлийг импортлон нутагшуулах, дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах, зөгийн үржлийн ажлыг сайжруулах, чадавхижуулах арга хэмжээг мэргэжлийн байгуулага, холбоодтой хамтран хэрэгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтын дэмжлэгээр зөгийн аж ахуйн кластерыг хөгжүүлэх;						
30	3.5.3. Зөгийн аж ахуйг чадавхижуулах, кластерын систем хөгжүүлэх арга хэмжээг гадаадын хөрөнгө оруулалтын дэмжлэгээр хэрэгжүүлнэ.	2019 - 2023			<ol style="list-style-type: none"> 1. АХБ-ны ХААНӨСД төслийн хүрээнд зөгийн балан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, тэдний гэрээт ханган нийлүүлэгч зөгийчид дээр тулгуурлан кластерийн тогтолцооны суурийг тавьж, мал эмнэлэг, тээвэр логистикийн ба худалдааны салбарын оролцогчдыг холбон ажиллаж байна. Шинээр батлагдан гарсан дүрэм, заавар, стандартуудыг НӨС-ний оролцогчдод танилцуулан мөрдүүлж хэрэгжүүлснээр кластерийн тогтолцоо бүрэн хэрэгжих болно. АХБ-ны төслийн дэмжлэгтэйгээр Зөгийн бал үйлдвэрлэн борлуулагч Гацуурт ХХК, Пермакултур хөгжил ХХК, Михачи ХХК ААН-үүд дээр төвлөрөн ханган нийлүүлэлтийн сүлжээ байгуулж 40 зөгийчин, зөгийн аж ахуйн үйлдвэрлэсэн балыг савлаж сүлжээ дэлгүүрээр худалдаалах ажил хийгдэж байна. Гацуурт ХХК “440” бренд Пермакултур хөгжл ХХК “Цэцэг” бренд, Михачи ХХК “Михачи” бренд Пермакултур ХХК Технож Бизнес Инкубатор Төв ба “Пан Монголика” ХХК-тай хамтран БНХАУ-д сүлжээ дэлгүүрээр зөгийн бал худалдаалж эхэлж байна. 2. ГХЯ, ЖДҮГ, ҮХГ, ДБ-ны Экспортыг дэмжих төсөл, USAID Бэст хөтөлбөр, Хөгжлийн шийдэл ТББ, Экспорт ОУХТөв, МҮХАҮТ хамтарсан “Экспорт Монгол - 2020” ОУ-ын цахим форум, виртуал үзэсгэлэнд оролцож Япон, Португали, Болгар улсын аж ахуйн нэгжүүдээс худалдан авах сонирхлоо илэрхийлж мэдээлэл солилцох шатанд явж байна. БНХАУ-руу зөгийн бал экспортлох нөхцлийг бүрдүүлэх зорилгоор ХХААХҮЯ дээр Ажлын хэсэг байгуулагдан БНХАУ-ын Гаалийн Ерөнхий Газраас ирүүлсэн импортын зөгийн баланд тавигдах эрүүл ахуй хорио цээрийн шаардлагад Монгол улсын хууль эрхзүйн орчин, үйлдвэрлэл хяналтын тогтолцоо хэрхэн нийцэж байгаа талаар шинжилгээ хийж хүргүүлсэн. 3. ЖАЙКА-аас байгууллагаас “Малын эмч нарын практик чадавхийг дээшлүүлэх төсөл”-ийг 2020 оны намраас хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү төсөлд Мал эмнэлгийн хүрээлэн (IVM) толгойлон Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори (SCVL), аймаг, сумын түвшний мал эмнэлгийн байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран зөгийн хачигтах өвчний тухай хамтарсан судалгаа хэрэгжүүлэхээр төслийн санал дэвшүүлээд байна. 	90%

3.6. Хот, суурингийн хүн амын хүнсний хэрэгцээнд эрчимжсэн аж ахуйгаас бэлтгэн нийлүүлэх сүү, мах, өндөг, зөгийн бал болон бусад түүхий эд, бүтээгдэхүүний хангамж, хүртээмж, аюулгүй байдлын баталгааг сайжруулах үйл ажиллагаанд бодлогын болон санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх.						
31	3.6.2. Цэцэрлэг, бага ангийн хоол, үдийн цайнд үнээний эрүүл, цэвэр сүү боловсруулж үйлдвэрлэсэн сүү, тараг өдөр бүр уулгах дэд хөтөлбөр хэрэгжүүлэх	2019 - 2023			“Үдийн цай” хөтөлбөрийн санхүүжилт БСШУСЯ-ны төсөвт тусгагддаг. Үндсэн байгууллагаар БСШУСЯ байх өөрчлөлтийг төлөвлөгөөнд оруулах санал 2 удаа өгсөн. “Дэлхийн сүүний өдөр”-ийг ХХААХҮЯ, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, дотоодын сүү боловсруулах үйлдвэрүүд хамтран “Эх орны сүү-Эрүүл хүнс” уриан дор 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдөр Сүү ХК-тай хамтран зохион байгуулж, 1200 цэцэрлэгийн хүүхэд, " Улаанчулуут" цэтг ажилладаг иргэдийн хүүхдүүдэд сүүний ач холбогдол таниулан сурталчилж сүү сүүн бүтээгдэхүүн бэлэглэсэн. Орон нутаг Дархан-Уул, Орхон аймгууд ЕБС-ийн 1-5 ангийн сурагчдад өдөр бүр сүү, сүүн бүтээгдэхүүн өгөх ажлыг зохион байгуулж байна.	100%
3.7. Эрчимжсэн аж ахуй, тариалангийн үйлдвэрлэлийг хослон эрхлэх үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, гурилын үйлдвэрүүдийг түшиглэн бүс нутгийн хэмжээний тэжээл үйлдвэрлэл, тэжээл хүргэлтийн үйлчилгээний ложистикийг хөгжүүлэх.						
32	3.7.1. Эрчимжсэн аж ахуй, тариалангийн үйлдвэрлэл хослон эрхлэх үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.	2019 - 2023			Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймгийн тариалангийн үйлдвэрлэл эрхлэдэг аж ахуйн нэгжүүдийг түшиглэн нийт 3000 үнээтэй сүүний чиглэлийн үхрийн 5 аж ахуйг байгуулна. Нийт зардал нь 91.0 тэрбум төгрөг Беларусь улсын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжинэ. Уг төслийн хүрээнд жилдээ 18.3 сая литр сүү нийлүүлнэ. 2020 онд төсөл сонгон шалгаруулалт зарлаж (Номун Тал ХХК, Газар-Агро ХХК, Мөнх-Орхон ХХК, Момо-Агро ХХК, Даваанбулаг ХХК)-ийг төсөл хэрэгжүүлэгчээр сонгон шалгаруулж, 3 аж ахуйн нэгжийн төсөл хэрэгжүүлэх боломжтой аж ахуйн нэгжүүдийн нөөцөд авсан. Шалгарсан аж ахуйн нэгжүүд ферм барих газрын хөрсний геодезийн шинжилгээ хийлгэсэн. Ферм барих барилгын аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулах бэлтгэл ажил хийгдэж байна.	50%
3.8. Одоо байгаа малын тэжээлийн үйлдвэр, цехийн тоо, байршил, хүчин чадлын ашиглалтын түвшинг тогтоож, тэжээлийн үндсэн түүхий эдийн нөөцийг бүрдүүлэхэд хөнгөлттэй зээлийн дэмжлэг үзүүлж, эрчимжсэн аж ахуйн хүчит тэжээлийн хангамжийг 30 хувиар сайжруулах.						
33	3.8.2. Эрчимжсэн аж ахуйн тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хүргэлтийн үйлчилгээг сайжруулна	2019 - 2023			Агро Фийд тэжээлийн үйлдвэрт улаан буудай, арвай, хивэг, халгай, өвсний гурил, рапсын шахдас, ургамлын тос, хужир, шүү, давс зэрэг дотоодын түүхий эд болон эрдэнэ шиш, шар буурцаг, үл орлогдох амин хүчил, витаминь бэлдмэлээр өсвөр шувуу, өндөглөгч тахианы 5 нэр төрлийн тэжээл, 6 нэр төрлийн малын тэжээл үйлдвэрлэж зах зээлд амжилттай нэвтрүүлж захиалга аван хүргэлтийн үйл ажиллагаа явуулан ажиллаж эхэлж байна.	70%
3.9. Тариалангийн 100,0 мянга хүртэлх га талбайд тэжээлийн ургамал тариалж, эрчимжсэн аж ахуйн шүүст болон ногоон тэжээлийн хангамжийг 50 хувиар нэмэгдүүлэх.						
34	3.9.1. Малын тэжээлийн ургамал тариалах талбайг эргэлтэнд оруулна.	2019 - 2023			2019 онд 42.0 мянган га талбайд тэжээлийн ургамал тариалсан бол 2020 оныд 55.4 мянган га талбайд тэжээлийн ургамал тариалж 10 гаруй мянган га талбайгаар нэмэгдүүлсэн байна.	70%
35	3.9.2. Эрчимжсэн аж ахуйн шүүст болон ногоон тэжээлийн хангамжийг эрс нэмэгдүүлнэ	2019 - 2023			Улсын хэмжээнд 2019 онд 16.1 мянган тн, 2018 онд 10.8 мянган тн, 2017 онд 9.3 мянган тн шүүст тэжээл бэлтгэж байсан бол 2020 онд 32.9 мянган тн шүүст тэжээл бэлтгэсэн байна. Энэ нь өмнөх оноос 2 дахин их хэмжээтэй бэлтгэсэн байна.	100%
4.3. Эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлийн сөрөг нөлөөллийг багасгах, хадлан, тэжээлийн өртгийг бууруулах хүчин зүйлсийг судлан тогтоож, мал, амьтны төрөл тус бүрт зориулагдсан тэжээллэгийн үр ашигтай хувилбаруудыг туршилтаар гаргахад бодлогын дэмжлэг үзүүлэх;						
36	4.3.2. Эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлийн	2019 - 2020			Улаанбаатар хотын засаг дарга Д.Сумъяабазартай санал солилцсоны дагуу Сонгино хайрхан дүүргийн нутаг дэвсгэрт Улаанбаатар хотод малын өвс, тэжээл, хивгийн нэгдсэн ЗАХ байгуулахаар	30%

	сөрөг нөлөөллийг багасгах хүчин зүйлсийг судалгааг хийнэ.				СХД-ийн Засаг дарга болон холбогдох албаны хүмүүстэй газар дээр нь ажиллаа. Ингэснээр өвс, тэжээл ченжүүдийн гар дамжин үнэ өртөг хэт өсөхгүй байх, өвс, тэжээлийг нэг цэгээс худалдан авах нөхцөл бүрдэх юм. Мөн Дундговь аймгийн Баянжаргалан сум, Эрдэнэдалай сум, Хэнтий аймгийн Батширээт сум, Өмнөдэлгэр сум, Хэрлэн сум, Дорнод аймгийн Хэрлэн сум, Сэргэлэн сум, Халхгол сум, Сүхбаатар аймгийн Сүхбаатар сум, Уулбаян сум, Түвшинширээ сумдад өвс,, тэжээл хадгалах цэгийг шинээр бий болгосон байна.	
37	4.3.3. Мал, амьтны төрөл тус бүрт зориулагдсан тэжээллэгийн туршилтууд хийнэ	2019 - 2021			<ol style="list-style-type: none"> 1. Хөдөө аж ахуйн их сургууль дээр цеолит, глицеринээр баяжуулсан хүчит багсармал тэжээлийн тэжээллэг чанарыг судалсан туршилтыг хийсэн байна. Мерси-Кор ОУБ-аас Булган аймгийн Тэшиг сумын "Мөнх түрүү" ХХК нь малын тэжээлийн 6 төрлийн жор гаргасан. 3-ийг нь үхэрт туршсан. Малчдад малын нэмэгдэл тэжээлийн ач холбогдлын талаар сургалт мэдээлэл хийсэн. 2. Мөн Хутаг-Өндөр сумын "Гурван борхууд" ХХК арвайн хаягдлаа ашиглан 2 төрлийн малын тэжээл үйлдвэрлэсэн. Дээрх 2 аж ахуйд малын тэжээл үйлдвэрлэх цех барих, тэжээл тариалах чиглэлээр 202.0 сая төгрөгийн дэмжлэг авч, үйлдвэрлэл явуулж байна. 3. Төв аймагт хөрсний үржил шимийг сайжруулах, тэжээлийн төрлийг нэмэгдүүлэх зорилгоор нийт таримлын 10 хувьд вандуй тариалах зөвлөмж, чиглэлийн хүрээнд 5600 га талбайд тариалалт хийж, 14.5 мян.тн ургац хураан авч малын тэжээлд хэрэглэж байна. Аргалант, Цээл сумдад тэжээлийн үйлдвэр ногоон тэжээл болон буудайн хаягдлаар малын тэжээл үйлдвэрлэн нийт 320 тн тэжээл нийлүүлсэн. 	70%
4.4. Дарш хийх, олон найрлагат хорголын, багсармал тэжээл, макро, микро элементээр баяжуулсан эрдсийн шахмал, уурагжуулсан, витаминжүүлсэн тэжээл үйлдвэрлэлд хөнгөлттэй зээлийн дэмжлэг үзүүлж, мал, амьтны төрөл, ашиг шимийн чиглэл, түвшин, физиологийн онцлогт нийцсэн төгс чанартай тэжээлээр хангах нөхцөл бүрдүүлэх;						
38	4.4.1. Эрчимжсэн мал аж ахуйн мал, амьтны төрөл, ашиг шимийн чиглэл, түвшин, физиологийн онцлогт нийцсэн төгс чанартай тэжээлээр хангах нөхцөл бүрдүүлнэ.	2019 - 2023			Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хороонд дэвшилтэд малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор техник, тоног төхөөрөмж бүхий сард 5000 тонн бүрэн найрлагат хорголын болон, багсармал бүх төрлийн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай бүрэн автомат тэжээлийн үйлдвэрийг шинээр ашиглалтад оруулсан. Бүрэн автомат үйлдвэр нь дотроо нэмэлтээр премиксийн үйлдвэр, тос шахах үйлдвэр, өвс бутлах, хорголын үйлдвэрүүд багтсан. Монголд анх удаа премиксийн үйлдвэрийг бий болгосноор мал, амьтны төрөл, ашиг шимийн чиглэл, түвшин, физиологийн онцлогт нийцсэн төгс чанартай тэжээлээр хангах боломжийг бүрдүүлсэн.	70%
4.5. Мах, махан бүтээгдэхүүн, өндөгний техникийн зохицуулалтыг боловсруулах, гахай, шувууны мах, өөхний стандартыг тогтоох, шинэчилэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;						
39	4.5.1. Мах, махан бүтээгдэхүүн, өндөгний техникийн зохицуулалтыг боловсруулж, батлуулан хэрэгжүүлнэ	2019 - 2021			Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтын төслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу дахин боловсруулж, эцэслэх ажил хийгдсэн. Мөн сүүлийн хувирлбарыг англи хэлрүү орчуулах ажил хийгдэж байна. ХХААХҮ-ийн сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. "Азийн хөгжлийн банкны ТА-8960 МОН Хөдөө аж ахуйн өртөгийн сүлжээг дэмжих төсөл, Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн Нэмэлт санхүүжилт төсөл"-ийн дэмжлэгтэйгээр боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтын төслийг мал төхөөрөх үйлдвэрийн удирдлагуудад цахим хэлбэрээр 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрөөс 18-ны хооронд зохион байгуулагдаж байна.	70%
4.6. Эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх бүс нутагт олон улсын жишигт нийцэхүйц үржил селекцийн чиглэлийн аж ахуй, явуулын үйлчилгээг бий болгох, үржүүлэг, технологийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх чадавхийг сайжруулах;						

40	4.6.1. Олон улсын жишигт нийцэхүйц үржил селекцийн чиглэлийн аж ахуй, явуулын үйлчилгээг бий болгоно	2019 - 2023		Дархан-Уул аймгийн Хонгор сумын 1-р баг Буурлын энгэр хэмээх газарт олон улсын жишигт нийцсэн тоног төхөөрөмж бүхий цогцолбор ашиглалтад ороод үйл ажиллагаа явуулж байна. 2020 онд орон нутгийн мал үржүүлгийн техникч нарын хэрэгцээнд захиалгын дагуу үр, азотоор явуулын үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Зохиомол хээлтүүлгийн 32 техникч нартай гэрээ байгуулан УБ хот, Төв, Сэлэнгэ, Булган, Орхон, Дархан-Уул аймгийн иргэн, аж ахуй нэгжд зохиомол хээлтүүлгийн явуулын үйлчилгээ үзүүлж 9290 малд зохиомол хээлтүүлгийн ажлыг 85.6-90.0 хувийн үр дүнтэй хийж гүйцэтгэв.	70%
41	4.6.2. Нийслэлийн үхэр сүрэгт ангилан ялгалт хийж үхрийн үүлдэр бүрээр нарийвчлан бүртгэлжүүлсэн тооллогыг жил бүр хийнэ	2019 - 2024		Нийслэлийн ХХААГ-ын даргын 2020 оны А/13 дугаар тушаалаар ажлын хэсэг томилогдон Малын удмын сангийн үндэсний төв, Мал үржүүлэг технологийн ажил, үйлчилгээний нэгж "Үржлийн шилмэл сүрэг" ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажиллав. Гэрээний дагуу 6 дүүргийн эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч өрх, аж ахуй нэгжийн үржилд ашиглаж буй нийт 263 буханд үзлэг хийж ашиг шимийн чиглэл болон үүлдэрлэг байдлаар шаардлага хангахгүй 121 бухыг үржлээс хасах тухай Мэргэжлийн хяналтын Улсын ахлах байцаагчийн 01-02-119/72, 01-02-199/51 дугаартай зөрчил арилгуулах тухай албан шаардлагыг 21, 32 дугаар хороодын Засаг дарга нарт хүргүүлж ажиллалаа. Шаардлага хангасан, баталгаажсан хээлтүүлэгчийг бүрэн гэрчилгээжүүллээ. Одоогийн байдлаар 880 үнэнд зохиомол хээлтүүлэг хийгээд байна.	100%
42	4.6.5. Малын үржил селекцийн аж ахуйн явуулын үйлчилгээг шинээр бий болгох	2019 - 2021		Сэлэнгэ аймгийн Хушаат сумын "Төгс ген" ХХК, Улаанбаатар хотын "Үржлийн шилмэл сүрэг хоршоо", "Нутаг академи" ТББ зэрэг үржлийн нэгж, байгууллагуудтай хамтран Улаанбаатар хотын СХД, Төв аймгийн Батсүмбэр, Баян-Өнжүүл сум, Сэлэнгэ аймгийн Хушаат, Ерөө, Цагааннуур сум, Дорноговь аймгийн Дэлгэрэх, Мандах, Өмнөговь аймгийн Гурван тэс зэрэг сумдад малын зохиомол хээлтүүлгийн явуулын пункт ажиллуулж нийт 1856 малд гойд ашиг шимт бух, хуц, ухны үрээр зохиомол хээлтүүлгийн ажил, үйлчилгээ хийв.	70%
43	4.6.6. Малын нөхөн үржүүлгийн техникч бэлтгэх сургалтыг бод, бог малын төрлөөр явуулах	2019 - 2021		Орон нутгийн мэргэжилтнүүдийн чадавхыг сайжруулах, мал үржүүлгийн техникч нарын тоог нэмэгдүүлэх, биотехнологийн дэвшилтэд аргыг ашиглан малын чанарыг богино хугацаанд сайжруулах зорилгоор бод, бог малын зохиомол хээлтүүлгийн үржүүлгийн техникч бэлтгэх сургалтыг Нийслэлийн ХХААГ, "Нутаг академи" ТББ, Бэлчээрийн менежмент төслийн нэгж зэрэг байгууллагуудтай хамтран 21-р хороо Нарийны фермер, Дархан-Уул аймгийн Хонгор суман дахь Малын удмын сангийн үндэсний цогцолборын үйлдвэрлэлийн байранд тус бүр 10 хоногийн онол, практик хосолсон сургалт зохион байгууллаа. Тус сургалтад Архангай, Өвөрхангай, Өмнөговь, Дундговь, Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Төв гэсэн найман аймгийн 16 сумын 20 мал зүйч, 10 малын эмч, 10 фермер эрхлэгч нийт 46 мэргэжилтнүүд хамрагдаж мэргэжлийн үнэмлэх сертификат гардуулан өглөө. Мөн амжилттай суралцсан зарим аймгийн мэргэжилтнүүдийг бод, бог малын зохиомол хээлтүүлгийн иж бүрэн багаж төхөөрөмжөөр хангаж ажиллалаа.	100%
44	4.6.7. Малд зохиомол хээлтүүлэг хийхэд шаардагдах багаж хэрэгсэл, шингэн азотоор хангах, бэлтгэн нийлүүлэх үйлчилгээг дэмжин хөгжүүлнэ.	2019 - 2023		<ol style="list-style-type: none"> 1. Улсын төсвийн 108,1 сая төгрөгийн санхүүжилтээр генийн санд үр хөлдөөж хадгалах 120-140 литрийн багтаамжтай тусгай зориулалтын био танк 6 ширхэг, Зохиомол хээлтүүлгийн бод, бог малын ком багаж 16 ширхгийг худалдан авч, тусгай орчинд байршуулж, генийн сангийн үр, үржүүлгийн материалыг хадгалах хадгалалтын орчин, нөхцөл, үржүүлгийн техникч нарын ажиллах нөхцөлийг сайжруулав. 2. Шингэн азотын үйлдвэрт нийт 3571 литр азот үйлдвэрлэж, генийн санд 2375,5 л, үр үйлдвэрлэлд 670л, гэрээт техникч нарт 251,5, иргэн аж ахуйн нэгжийн захиалгаар 310 литр шингэн азотоор хангаж ажиллав. 	100%

					3. Швейцарийн хөгжил хамтын ажиллагааны агентлагаас хэрэгжүүлж буй “Ногоон алт” төсөлтэй хамтран Төв аймгийн Борнуур, Сүмбэр суманд ажиллах зохиомол хээлтүүлгийн техникчийг сургаж бэлтгэн тус бүр 4.0 сая төгрөгийн зохиомол хээлтүүлгийн багаж хэрэгслээр хангав.	
45	4.6.8. Малын үржүүлэг, технологийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх чадавхийг сайжруулна.	2019 - 2023	-		<ol style="list-style-type: none"> 1. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийг дэмжих зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж буй үзлэг, ангилалтын ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх, нэгжийн мэргэжилтнийг мэргэшүүлэх, давтан сургах, багаж тоног төхөөрөмжөөр үе шаттай хангах ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулав. 2020 онд улсын төсвийн 430.0 сая төгрөгийн хөрөнгөөр хийгдсэн малын үзлэг ангилалтын ажлыг 59 мал үржүүлэг технологийн нэгжтэй гэрээ байгуулж гүйцэтгүүлэв. 2. Мөн орон нутгийн төсвийн 216.0 сая төгрөгийн санхүүжилтээр Архангай, Өвөрхангай, Дундговь, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн 13 мэргэжлийн нэгжид зоо багаж хэрэгсэл, үржлийн мал нийлүүлэх тендер сонгон шалгаруулалтыг орон нутгийн мэргэжлийн байгууллага зохион байгуулж хэрэгжүүлэв. 3. Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийг шинээр байгуулах, үүсгэл санаачилгыг дэмжих чиглэлийг бүх шатны мэргэжлийн байгууллагад хүргүүлж ажилласнаар 2020 онд улсын хэмжээнд Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний 131 нэгж тогтмол үйл ажиллагаа явуулж байна. 4. Нэгжид ажиллаж буй мал зүйч мэргэжилтнийг мэргэшүүлэх, мэргэжлийн зэрэг дэв олгох ажлыг зохион байгуулж, ХХААХҮСайдын 2020 оны А-386 дугаар тушаалаар 11 мал зүйчид "Зөвлөх мал зүйч", 3 мал зүйчид "Тэргүүлэх мал зүйч" мэргэжлийн зэрэг олгов. 5. 21 аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын мал үржлийн албанд тус бүр ангилалтын иж бүрэн багаж, бог, бодын зохиомол хээлтүүлгийн багаж хэрэгслийг олгов. 	100%
4.8. Өндөр ашиг шимт малын үр, хөврөлийг малын генийн санд хадгалах, гүн хөлдөөсөн болон хүйс жолоодсон үрийг ашигласан зохиомол хээлтүүлгийн ажлын цар хүрээг тэлэх, хөврөл үйлдвэрлэх, шилжүүлэн суулгах биотехнологийн ололтыг нэвтрүүлэх арга хэмжээг дэмжих;						
46	4.8.1. Өндөр ашиг шимт малын үр, хөврөлийг малын генийн санд хадгалах арга хэмжээг хэрэгжүүлнэ	2019 - 2023			<ol style="list-style-type: none"> 1. Малын генетик нөөцийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.1, 15.2.2 дахь заалтын дагуу Хаврын үр үйлдвэрлэлийн ажлын хүрээнд Махны чиглэлийн Сэлэнгэ, Герфорд, Сүүний чиглэлийн Швейцын бор, Хар тарлан үүлдрийн 10 бухаас 5500 тун үр стандартын дагуу үйлдвэрлэн генийн санд баяжилт хийж, үржүүлгийн техникч нарыг захиалгын дагуу үржүүлгийн бүтээгдэхүүнээр ханган ажиллалаа. 2. Намрын үр үйлдвэрлэлийн ажлын хүрээнд тоо толгой цөөрч доройтож мөхөх, устахаас хамгаалах зорилгоор Баянхонгорын Бөмбөгөрийн улаан 3 ухна, Увс аймгийн Баяд үүлдрийн 3 хуц, Завхан аймгийн Сартуул үүлдрийн 3 хуцнаас 4800 тун үр үйлдвэрлээд байна. 3. Мөн "Тайшир-Өргөө" ХХК-д үржүүлж байгаа Суффольк, Романов, Брекшон, Дүйчер, Меринос 5 үүлдрийн хуцыг түрээслэн авч 2500 тун үрийг стандартын шаардлага хангасан орчинд, технологийн дагуу авч генийн санд хадгалав. Нийт 12800 тун үр үйлдвэрлэв. 	100%
47	4.8.2. Зохиомол хээлтүүлгийн ажлын цар хүрээг тэлэх	2019 - 2023			<ol style="list-style-type: none"> 1. Нийслэл, орон нутагт ажиллаж байгаа мал үржүүлгийн 32 техникчтэй гэрээ байгуулан иргэд, аж ахуйн нэгж, иргэдийн нийт 6953 үнээнд 1-11 дүгээр сард зохиомол хээлтүүлгийн ажил үйлчилгээ үзүүлэн хээлийн шалгалтаар 85.6 хувийн үр дүнтэй хээл авав. Дээрх зохиомол 	100%

				<p>хээлтүүлэгт хамрагдсан үнээнээс 1800 үнээний мэдээллийг үржлийн бүртгэл мэдээллийн санд оруулж баяжилт хийсэн байна.</p> <p>2. Малын удмын сангийн мэргэжилтнүүд орон нутагт очиж ажиллан Дорноговь аймгийн Мандах сумын 2 малчны суурийн 570 эм ямаанд Дэлгэрхэхийн улаан омгийн ухны шингэн үрээр, Төв аймгийн Баян-Өнжүүл сумын малчин Батжаргалын 340 эм хонинд цэвэр үүлдрийн Суффольк хуцны шингэн үрээр, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын малчин Алтансүхийн 100 эм ямаанд цэвэр сүүний чиглэлийн Заанен үүдрийн ухны шингэн үрээр тус тус зохимол хээлтүүлэг хийв.</p> <p>3. Мөн орон нутагт ажиллаж байгаа үржүүлгийн техникч нартай гэрээ байгуулан биотехнологийн дэвшилтэд аргыг ашиглан малын чанарыг богино хугацаанд сайжруулах зорилгоор Хэнтий аймгийн Биндэр сумын 1 суурийн 80 эм хонинд Суффольк хуцны шингэн үрээр, Хэнтий аймгийн Баянхутаг сумын 1 суурийн 80 эм хонинд Суффольк хуцны шингэн үрээр, 70 эм хонинд Эделбайв үүлдрийн хуцны шингэн үрээр, Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын 1 суурийн 80 эм хонинд Суффольк хуцны шингэн үрээр, Архангай аймгийн орон нутгийн өмчийн цөм сүргийн нэгжийн 300 эм хонинд Эделбайв үүлдрийн хуцны шингэн үрээр, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 суурийн 107 эм хонинд Барга үүлдрийн хуцны шингэн үрээр, Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын 1 суурийн 90 эм хонинд Эделбайв үүлдрийн хуцны шингэн үрээр, Төв аймгийн Сэргэлэн сумын 1 аж ахуйн нэгжийн 600 эм хонинд Допер, Суффольк хуцны шингэн үрээр тус тус зохиомол хээлтүүлэг хийв. Энэ ажлын хүрээнд 9-10 дугаар сард нийт 2337 толгой бог малд зохимол хээлтүүлэг хийсэн. Нийт 9290 малд зохимол хээлтүүлгийн ажлыг 85.6-90.0 хувийн үр дүнтэй хийж гүйцэтгэв.</p>	
48	4.8.3. Хүйс жолоодсон үр, хөврөл үйлдвэрлэх, шилжүүлэн суулгах биотехнологийн ололтыг нэвтрүүлэх арга хэмжээг дэмжинэ.	2019 - 2023		<p>1. Хар тарлан, Алату зэрэг 15 хээлтэгч малд хүйс жолоодсон гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийж, практикт суурилсан сургалт зохион байгуулав.</p> <p>2. “Түмэн шувуут” ХК-тай хамтран Төв аймгийн Сэргэлэн сумд 250 эм хонинд, “Кайзер флашерай” ХХК-тай хамтран Булган аймгийн Дашинчилэн суманд 300 эм хонинд тус тус махны чиглэлийн цэвэр үүлдрийн Дорпер хонины хөврөл үр суулгах ажлыг зохион байгуулав.</p> <p>3. Япон Улсын Сецүро Тек Инк, Оптейж Инк компанитай Монголын ноолуулын “Залаа жинст”-ийн цагаан ямаанд геном шилжүүлэн суулгах туршилт, судалгааг хамтран хэрэгжүүлэх, Монголд нарийн мэргэжлийн боловсон хүчнийг сургаж, бэлтгэх чиглэлээр гэрээг байгуулав.</p>	90%
4.10. Гахай, тахианы эрчимжсэн аж ахуйд ашиглагддаг малын эмийг улсын бүртгэлийн жагсаалтад оруулах, мал эмнэлгийн үйлчилгээний гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын санхүүжилтийн ялгавартай байдлыг арилгах;					
49	4.10.2. БНХАУ-аас үржлийн гахай импортлох 1995 оны хэлэлцээрийг шинэчлэх асуудлыг судалж, галуудын шийдвэрийн тохиролцоонд хүрнэ.	2019 - 2023		<p>Монгол Улсад 2019 онд малын гоц халдварт гахайн африкийн мялзан өвчний тохиолдол бүртгэгдсэн даруйд "Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль", Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 266 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам", Мал эмнэлгийн ерөнхий газрын 2019 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан "Гахайн африкийн мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх түр заавар"-ын тэмцэх арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж, халдвар импортоор орж ирэх магадлалтай тул Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 01-р сарын 16-ны өдрийн А-18 дугаар “Гахай мах, өөх махан бүтээгдэхүүнийг улсын хилээр түр хугацаагаар импортлохыг хориглох тухай”</p>	30%

				тушаалаар гахайн түүхий эд бүтээгдэхүүний импортыг хязгаарлах шийдвэр гарсан. Улсын хэмжээнд гахайн африк мялзан өвчнийг илрүүлэх идэвхтэй тандалт, судалгааг хийж Монголд өвчний эрсдэл үгүй болохыг тогтоож удалгүй гахайн түүхий эд бүтээгдэхүүний импортыг хязгаарлах шийдвэрийг цуцалсан байна. ДМАЭМБ-ын зөвлөмжөөр Монгол Улсын хилээр орж ирж байгаа гахайн бүтээгдэхүүн бүрд гахайн африкийн мялзан өвчний лабораторийн шинжилгээ хийгдэж байгаа бөгөөд 2020 онд цар тахал гарсантай холбогдуулан 1995 оны гэрээг шинэчлээгүй байгаа болно.	
4.11. Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд чанарын үзлэг, шинжилгээ хийх, зохиомол хээлтүүлэг явуулах, малд үзлэг, ангилалт хийхэд шаардагдах багаж, хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх;					
50	4.11.2. Малд зохиомол хээлтүүлэг явуулах, малд үзлэг, ангилалт хийхэд шаардагдах багаж, хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлнэ.	2019 - 2023		Малын генийн сангийн үрийг тусгай зориулалтын биобанкинд хадгалах, зохиомол хээлтүүлгийн ажил, үйлчилгээг өргөтгөх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх зорилгоор "Малын генийн үр хадгалах биобанк, зохиомол хээлтүүлгийн тоног төхөөрөмж худалдан авах тендерийн баримт бичиг боловсруулж, 2020 оны 05 сарын 24-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим тендерт байршуулан худалдан авах ажлыг зохион байгуулав. Тендерт гүйцэтгэгчээр шалгарсан "Даянгүн орд" ХХК-тай 2020 оны 06 сарын 11 ны өдөр "Малын генийн үр хадгалах биобанк, зохиомол хээлтүүлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх " МУСҮТ/2020/01 дугаартай гэрээг байгуулан төвийн захирлын 2020 оны 07 сарын 27 ны А/31 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг техникийн тодорхойлолтын дагуу тоног төхөөрөмжийг хүлээн авав. Худалдан авсан 120-150 литрийн багтаамжтай биотанкийг малын генийн сангийн байранд суурилуулан бод, бог малын зохиомол хээлтүүлгийн 16 ширхэг иж бүрдэл багажийг төвийн захирлын 2020 оны 09 сарын 21 ны А-40 тоот тушаалийн дагуу техникч нарт хуваарилан олгов. 21 аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын мал үржлийн албанд тус бүр 1 ширхэг бог, бодын зохиомол хээлтүүлгийн багаж хэрэгслийг хүргүүлэв.	100%
4.12. Гойд ашиг шимт үржлийн малын үзэсгэлэн, үнэ хаялцуулах худалдаа, эрчимжсэн мал аж ахуйн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, техник, технологийн үзэсгэлэнг улсын хэмжээнд тогтмол зохион байгуулах.					
51	4.12.1. Гойд ашиг шимт үржлийн малын үзэсгэлэн, худалдаа, техник, технологийн үзэсгэлэнг улсын хэмжээнд тогтмол зохион байгуулна	2019 - 2023		<ol style="list-style-type: none"> 1. Ковид-19 цах тахлаас шалтгаалж улсын хэмжээнд Гойд ашиг шимт малын үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдаагүй. Завхан аймагт зохион байгуулагдсан “Малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлж, цочролд хариу үзүүлэх бэлэн байдлыг нэмэгдүүлэх нь” нэгдсэн арга хэмжээний хүрээнд тус аймгийн 24 сумын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүд, малчдыг мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг хийж гүйцэтгэв. Зөвлөгөөнд "Малын генетик нөөцийн төлөв байдал, мал аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжлийн чиг хандлага" сэдвээр илтгэл хэлэлцүүлж, сумдын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдэд 1 өдрийн сургалт зохион байгуулав. 2. Завхан аймгийн Шилмэл малын үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, гойд ашиг шимт малын шалгаруулалтыг орон нутгийн мэргэжлийн байгууллагатай хамтран хийв. 3. Архангай аймгийн засаг даргын захирамжаар "Архангай түншлэл 2020" Шимэл малын үзэсгэлэн худалдааг 9 дүгээр сарын 24-25 ны өдрүүдэд аймгийн төвд зохион байгуулж нийт 13 сумын 15 малчин , 2 аж ахуй нэгжийн 122 толгой мал үржлийн мал оролцсон. Үүнээс 73 толгой үржлийн шилмэл малд үндсэн хэмжилтүүд хийж гойд ашиг шимт малыг 4 төрлөөр шалгаруулсан. Шилмэл малын үзэсгэлэн худалдаанд оролцож шалгарсан хээлтүүлэгч малын үзүүлэлтээс харахад өнгөрсөн жилүүдийн үзүүлэлтүүдээс 15-20 хувь доогуур байгаа нь энэ жил зуншлага оройтож болж мал сүрэг тарга хүч бүрэн авч чадаагүйг харуулж байна. 	70%

					4. Баян-Өлгий аймагт гойд ашиг шимт үржлийн мал шалгаруулах, өндөр ашиг шимтэй мал, амьтныг олон нийтэд сурталчлах, малчид, харилцан туршлага солилцох зорилгоор “Шилмэл мал-2020” үзэсгэлэн худалдааг аймгийн төвд 9-р сарын 04-05 өдрүүдэд зохион байгуулав. Үржлийн малын үзэсгэлэн худалдаанд 8 сумаас 45 толгой мал оролцуулсан. Керей үүлдрийн хуц, Уулын бор үүлдрийн ухныг амьдын жин, бие цогцосоор, ямааг сүүний гарц, ноолуурын гарцаар, үхрийг амьдын жин, сүүний гарц бие цогцосоор тус тус шалгаруулалт хийгдсэн.	
5.1. Мал, амьтны сүргийн нөхөн үйлдвэрлэлийг мөчлөгийн үр ашигтай системд шилжүүлж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн улирлын хамаарлыг үе шаттай бууруулах;						
52	5.1.1. Мах, сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйнуудын бүтээгдэхүүн нийлүүлэлтийн төлөвлөлт хийж, үйлдвэрлэлийн улирлын хамаарлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2019 - 2023	-		1. 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн Засгийн газрын 130 дугаар тогтоолоор Сүүний урамшуулал олгох журмыг баталсан. Журамд заасан шаардлага хангасан сүүг Үндэсний статистикийн хорооны 2019 оны мал тооллогын А дансны бүртгэлтэй, сүүний үйлдвэрт нийлүүлсэн сүүгээ и-баримтад бүртгүүлэн баталгаажуулсан малчин, эрчимжсэн мал аж ахуйн эрхлэгчдэд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалын дагуу мөнгөн урамшуулал олгож эхэлсэн. Энэ ажил маань мах, сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйнуудын бүтээгдэхүүн нийлүүлэлтийн төлөвлөлт хийж, үйлдвэрлэлийн улирлын хамаарлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд ихээхэн үр дүнгээ өгч эхлэлээ. 2. Бэлтгэж, нөөцөлсөн махыг хөнгөлөлттэй үнээр худалдан борлуулах ажлыг 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөс эхлүүлсэн. Нөөцийн махыг Нийслэлийн 9 дүүргийн 169 хорооны хүнсний 413 дэлгүүрээр дамжуулан хонины ястай мах 6700 төг/кг, үхрийн ястай мах 7700 төг/кг, ямааны мах 6200 төг/кг үнээр худалдаанд гаргасан. Нөөцийн махны худалдааг 2020 оны 7 дугаар сарын 10-ны өдөр хүртэл нийслэлийн хүн амд худалдаалж, нийт 10.5 мянган тн махыг нийлүүлээд байна. Нийслэлийн хүн амын 2020 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд доор дурдсан байдлаар махны нөөцийг бүрдүүлсэн. Үүнд: 1. Арижааны банкны эх үүсвэрээр: 12 аж ахуйн нэгж, нийт 8857,0 тн, Үүнээс: үхрийн ястай мах 2025 тн, хонины ястай мах 4968 тн, ямааны ястай мах 1864 тн 2. Өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр: 4 аж ахуйн нэгж, нийт 552,0 тн, Үүнээс: үхрийн ястай мах 305,3 тн, хонины ястай мах 194,0 тн, ямааны ястай мах 52,6 тн 3. Бодлогын гэрээгээр мал, мах бэлтгэсэн: 22 аж ахуйн нэгж, нийт 1102 тн, Үүнээс: сүлжээ дэлгүүрээр 623,14 тн, хүнсний дэлгүүрээр 479.26 тн Тухайн арга хэмжээг Нийслэлийн Захирагчийн ажлын албатай хамтран хэрэгжүүлсэн.	70%
5.2. Мал, амьтны төрөл, үүлдэрлэг байдал, ашиг шимийн гарцтай уялдуулан сүрэгт явуулах үржүүлгийн хөтөлбөрийг шинэчилж, сүргийн хээлтүүлэг, төллөлтийг технологийн дагуу удирдаж, аж ахуйн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх;						
53	5.2.1. Эрчимжсэн аж ахуйн сүрэгт явуулах үржүүлгийн хөтөлбөр, хээлтүүлэг, төллөлтийн графикийг шинэчилж, аж ахуйн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ	2019 - 2023	-		“Үржлийн малд хянан магадлагаа хийх, баталгаажуулах, үүлдэрлэг байдлыг тодорхойлох, хяналт тавих журам”-ын төслийг Хууль зүй, дотоод хэргийн Сайдын 2018 оны А/147 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу боловсруулж, олон нийтийн оролцоог хангах, эерэг, сөрөг талуудыг харьцуулан судалж үр дагаврыг урьдчилан тооцох зарчмаар бүх шатны хэлэлцүүлгийг зохион байгуулсан болно. Хэлэлцүүлгээс гарсан саналыг нэгтгэн боловсруулж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2018 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А-145 дугаар тушаалаар баталж, Захиргааны хэм хэмжээний актын 3991 дугаарт бүртгүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Журмын хүрээнд ХХААХҮСайдын тушаалаар томилогдсон ажлын хэсэг 2020 онд 4 аймгийн 4 суманд үржүүлж буй нутгийн шилмэл малд хянан магадлагаа хийж, тайланг ХХААХҮСайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлснээр 1 үүлдрийн хэсэг, 1 үржлийн хэсэг, 2 омог шинээр баталгаажиж, Монгол Улсад баталгаажсан үүлдэр, омгийн мал 56 боллоо. Журмын дагуу шинээр баталгаажиж буй	50%

					үүлдрийн малд 10, омгийн малд 5 жилийн үржил селекцийн ажлын хөтөлбөрийг боловсруулан ХХААХҮСайдын тушаалаар баталгаажуулан хэрэгжилтийг хангуулж байна.	
54	5.2.2. Эрчимжсэн аж ахуйд мал сүргийн бүтцийн зохистой харьцааг бий болгох замаар бэлчээрийн доройтлыг бууруулах судалгаа, арга хэмжээг хэрэгжүүлэх	2019 - 2023	-		Баталгаажсан үүлдэр омгийн малыг үржүүлэх стратеги төлөвлөгөөг баталсан бөгөөд энэхүү төлөвлөгөөнд тухайн төрөл, үүлдэр омгийн малыг үржүүлэх бүс нутгийн асуудал тусгагдсан болно. Эрчимжсэн МАА эрхлэх бүс нутгийг тогтоох судалгааны хүрээнд нарийн ноост “Хангай” үүлдрийн хонийг хээрийн бүсэд үржүүлж болох эсэх талаар судалгаа хийсэн бөгөөд энэ ажлын үр дүнд Хангай хонийг зөвхөн ойт хээрийн бүсэд үржүүлэх нь үр дүнтэй гэсэн дүгнэлт гараад байна.	50%
5.3. Зах зээлд бэлтгэн нийлүүлэх түүхий эд, бүтээгдэхүүний чанар, хүнсний сүлжээний аюулгүй байдлыг баталгаажуулах бүртгэлийн системийг мэргэжлийн байгууллага, холбоодын үйл ажиллагаанд суурилан кластер, цогцолбор тус бүрт хэрэгжүүлэх;						
55	5.3.1. Зах зээлд бэлтгэн нийлүүлэх түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг баталгаажуулах бүртгэлийн системийг эрчимжсэн аж ахуйнуудад нэвтрүүлнэ.	2019 - 2023	-		Зах зээлд бэлтгэн нийлүүлэх түүхий эдийн аюулгүй байдлыг Мал эмнэлгийн ерөнхий газраас хэрэгжүүлж буй мал эмнэлгийн нэгдсэн бүртгэл мэдээллийн системийг ашиглаж байна. ХХААХҮЯ-наас тухай бүр мэдээллийг авч, хянаж байна. Тухайн системийг үйлдвэрлэлд ашигласнаар үйлдвэрлэлийн аргаар болосруулах бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэх, цаашид хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал хангагдах нөхцөл бүрдэж байна.	70%
5.4. Боловсруулах үйлдвэрт нийлүүлэх мах, сүүний улирлын хамаарлыг бууруулах, хангамжийг нэмэгдүүлэх, аюулгүй байдлын баталгааг хангах хөшүүргийг урамшууллын системээр дамжуулж бий болгох, төлөвшүүлэх.						
56	5.4.2. Боловсруулах үйлдвэрт нийлүүлэх махны улирлын хамаарлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ	2019 - 2023	-		Бэлтгэж, нөөцөлсөн махыг хөнгөлөлттэй үнээр худалдан борлуулах ажлыг 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөс эхлүүлсэн. Нөөцийн махыг Нийслэлийн 9 дүүргийн 169 хорооны хүнсний 413 дэлгүүрээр дамжуулан хонины ястай мах 6700 төг/кг, үхрийн ястай мах 7700 төг/кг, ямааны мах 6200 төг/кг үнээр худалдаанд гаргасан. Нөөцийн махны худалдааг 2020 оны 7 дугаар сарын 10-ны өдөр хүртэл нийслэлийн хүн амд худалдаалж, нийт 10.5 мянган тн махыг нийлүүлээд байна. Нийслэлийн хүн амын 2020 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд доор дурдсан байдлаар махны нөөцийг бүрдүүлсэн. Үүнд: 1. Арижааны банкны эх үүсвэрээр: 12 аж ахуйн нэгж, нийт 8857,0 тн, Үүнээс: үхрийн ястай мах 2025 тн, хонины ястай мах 4968 тн, ямааны ястай мах 1864 тн 2. Өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр: 4 аж ахуйн нэгж, нийт 552,0 тн, Үүнээс: үхрийн ястай мах 305,3 тн, хонины ястай мах 194,0 тн, ямааны ястай мах 52,6 тн 3. Бодлогын гэрээгээр мал, мах бэлтгэсэн: 22 аж ахуйн нэгж, нийт 1102 тн, Үүнээс: сүлжээ дэлгүүрээр 623,14 тн, хүнсний дэлгүүрээр 479.26 тн Тухайн арга хэмжээг Нийслэлийн Захирагчийн ажлын албатай хамтран хэрэгжүүлсэн.	100%
57	5.4.3. Махны чиглэлийн өсвөр үхрийг эрчимтэй бордох, худалдах бусад улс орны туршлагыг нутагшуулна.	2019 - 2023	-		<ol style="list-style-type: none"> 1. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын "Занадуразербак" ХХК, Сэлэнгэ сумын "Эрэн бухт" ХХК, хангал сумын "Эко хан буян" ХХК -иуд мал бордох технологийг үр дүнтэй ашиглаж, махны чиглэлийн өсвөр үхрийг эрчимтэй бордох жидийн 4 улиралд зах зээлд мах борлуулж байна. 2. Увс, Дорнод аймгийн эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч, малчид, иргэдийн төлөөлөл 115 хүн Хутаг-Өндөр сумын “Занадуразербак” ХХК-ны мал бордох, мах үйлдвэрлэлийн үйл 	100%

					ажиллагаатай танилцсан. Занадуразербак” ХХК-нь Канад улсын үхэр бордох туршлагыг монголд нутагшуулж байгаа болно.	
6.2. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутагт газар тариалан, мал аж ахуйн хосолсон үйлдвэрлэл хөгжүүлэх, инновацийг нэвтрүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх, ажлын байр шинээр бий болгох санал, санаачилгыг хөрөнгө оруулалтын болон татварын бодлогоор дэмжих;						
58	6.2.1. Газар тариалан, мал аж ахуйн хосолсон үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.	2019 - 2023	-		Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймгийн тариалангийн үйлдвэрлэл эрхлэдэг аж ахуйн нэгжүүдийг түшиглэн нийт 3000 үнээтэй сүүний чиглэлийн үхрийн 5 аж ахуйг байгуулна. Нийт зардал нь 91.0 тэрбум төгрөг Беларусь улсын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжинэ. Уг төслийн хүрээнд Жилдээ 18.3 сая литр сүү нийлүүлнэ. 2020 онд төсөл сонгон шалгаруулалт зарлаж (Номун Тал ХХК, Газар-Агро ХХК, Мөнх-Орхон ХХК, Момо-Агро ХХК, Даваанбулаг ХХК)-ийг төсөл хэрэгжүүлэгчээр сонгон шалгуулж, 3 аж ахуйн нэгжийн төсөл хэрэгжүүлэх боломжтой аж ахуйн нэгжүүдийн нөөцөд авсан. Шалгарсан аж ахуйн нэгжүүд ферм барих газрын хөрсний геодозийн шинжилгээ хийлгэсэн. ферм барих барилгын аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулах бэлтгэл ажил хийгдэж байна.	50%
59	6.2.2. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлд инновацийг нэвтрүүлж, бүтээмжийг дээшлүүлнэ.	2019 - 2023	-		<ol style="list-style-type: none"> 1. ХХААХҮЯамны захиалгаар ХААҮШҮОНТ 2019 онд хэрэгжиж дууссан мал аж ахуйн-1, мал эмнэлэг-2, газар тариалан-8, хөнгөн үйлвэрлэл-2, нийт 12 төслийн үр дүнгийн үнэлгээг нэгтгэн боловсруулав Мал аж ахуй: - “Монгол улсын махны чиглэлийн үхэр, хонины удам зүйн үнэлгээг хийх, монгол малын махны тодорхой генийг молекулын биологийн аргаар тогтоох судалгаа” - Мал эмнэлэг: - “Малын тэсвэрт чанарыг дээшлүүлэх, дархлаа тэтгэх, мах сүүний гарц нэмэгдүүлэх шинэ бэлдмэлийн технологи, малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнд эмийн үлдэгдэл шалгах арга аргачлал, жишиг лаборатори” - Экологиос хамааралтай мал, амьтны өвчин эмгэгийн оношлогоо, эмчилгээний технологи боловсруулах” зэрэг болно. 2. 2020 оны эхний хагас жилд Швейцарийн хөгжлийн агентлагийн Ногоон алт-Малын эрүүл мэнд төсөлтэй “Мал аж ахуй, газар тариалан хосолсон бүсэд бэлчээр ашиглалтын гэрээний туршлагыг нэвтрүүлэх” чиглэлээр, КОПИА-МОНГОЛ төвийн сургалт, туршилт үйлдвэрлэлийн Загвар аж ахуйн тохижилтыг сайжруулах төсөл, Япон улсын Кацүра Сэйки Сэйсакү Шо ХХК-тай “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмжийг туршилтаар суурилуулахад хамтран ажиллах тухай санамж бичиг байгуулсан. “Герман Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төсөл, “Хариуцлагатай нүүдэлчин” стандартыг хэрэгжүүлэхээр “Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо” ТББ зэрэг төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж байна. 3. Өвөрхангай аймагт 45 иргэн, аж ахуй нэгж оролцож Аймгийн эрчимжсэн мал аж ахуйн өнөөгийн байдал цаашдын зорилт илтгэл, Батлан даалтын сангийн мэдээлэл, ЖДҮйлдвэрийн төслийн талаар, эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлд техник, технологийн шинэчлэл, инновацийг нэвтрүүлэх талаар зөвлөлдсөн. Зөвлөгөөний үеэр малын тэжээл, хадлан бэлтгэх хөдөлмөр хөнгөвчилсөн гар аргаар хийсэн тоног төхөөрөмжийн үзэсгэлэн зохион байгуулагдсан. 	30%
60	6.2.3. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлнэ.	2019 - 2023	-		2020 онд эрчимжсэн аж ахуйн чиглэлээр аймгууд зээл олгосон байна. Өвөрхангай 2020 онд “Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан” болон “Сум хөгжүүлэх сан”-гаас Арвайхээр, Хархорин, Сант, Есөнзүйл, Баян-Өндөр, Зүүнбаян-Улаан, Тарагт, Баруунбаян-Улаан Бат-Өлзий сумдын 134 иргэн, аж ахуйн нэгжид 654.0 сая төгрөгийн зээл Өмнөговь аймагт ЖДҮХС-аас орон нутгийн хөрөнгөөр хөнгөлөлттэй зээл олгож Гурвантэс суманд сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр "Хөвдийн алтан	100%

					тоорой" ХХК-нд 48 сая төгрөг, Даланзадгад суманд "Сүүн дэгжих" ХХК-нд 90 сая төгрөг, малын гэжээл үйлдвэрлэлээр Номгон сумын "Бат-Амгалан хөрх" хоршоонд 74 сая, Даланзадгад суманд мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр "Тананжин" ХХК-нд 21 сая төгрөгийн зээл олгож, үйл ажиллагааг нь дэмжсэн байна.	
7.1. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид туршлага, мэдээллээ харилцан солилцох, судлах, технологийн болон эдийн засгийн мэдлэгээ сайжруулахад чиглэгдсэн олон талт сургалтыг зохион байгуулж, чадавхижуулах, мэдээллээр хангах нөхцлийг бүрдүүлэх						
61	7.1.1. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд технологийн болон эдийн засгийн мэдлэгээ сайжруулахад чиглэгдсэн олон талт сургалтыг зохион байгуулж, мэдээллээр хангана.	2019 - 2023	-		Орон нутагт дахь мэргэжилтнүүдийн чадавхыг сайжруулах, мал үржүүлгийн техникч нарын тоог нэмэгдүүлэх, биотехнологийн дэвшилтэд аргыг ашиглан малын чанарыг богино хугацаанд сайжруулах зорилгоор бод, бог малын зохиомол хээлтүүлгийн үржүүлгийн техникч бэлтгэх сургалтыг Нийслэлийн ХХААГ, "Нутаг академи" ТББ, Бэлчээрийн менежмент төслийн нэгж зэрэг байгууллагуудтай хамтран 21-р хороо Нарийны фермер, Дархан-Уул аймгийн Хонгор суман дахь Малын удмын сангийн үндэсний цогцолборын үйлдвэрлэлийн байранд тус бүр 10 хоногийн онол, практик хосолсон сургалт зохион байгууллаа. Тус сургалтад Архангай, Өвөрхангай, Өмнөговь, Дундговь, Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Төв гэсэн найман аймгийн 16 сумын 20 мал зүйч, 10 малын эмч, 10 фермер эрхлэгч нийт 46 мэргэжилтнүүд хамрагдаж мэргэжлийн үнэмлэх сертификат гардуулан амжилттай суралцсан зарим аймгийн мэргэжилтнүүдийг бод, бог малын зохиомол хээлтүүлгийн иж бүрэн багаж төхөөрөмжөөр хангаж ажиллаа.	70%
62	7.1.2. Эрчимжсэн мал аж ахуйн техник, технологи, ололтын үзэсгэлэнг 2 жилд тутамд нэг удаа зохион байгуулна.	2019 - 2023	-		<ol style="list-style-type: none"> 1. Салбарын үйлдвэрлэлд мал зүйн шинжлэх ухаан, орчин үеийн биотехнологи, молекул биологийн шинэ дэвшилт арга, технологийг нэвтрүүлэхтэй холбогдсон туршилт, судалгаа явуулж, мал зүйч мэргэжилтнүүдийг давтан сургаж, дадлагажуулах чиглэлээр ХААИС-ийн Мал аж ахуй, биотехнологийн сургууль, Малын удмын сангийн үндэсний төв хооронд "Хамтран ажиллах санамж бичиг"-ийг 2020 оны 02 дугаар сарын 19-ны өдөр байгуулан түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна. 2. Шинжлэх ухаан, судалгаа, үйлдвэрлэлийн чиглэлээр хамтран ажиллах зорилгоор Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Малын удмын сангийн үндэсний төвийн хооронд хамтран ажиллах 04/02 дугаартай "Санамж бичиг"-ийг 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр байгуулан төлөвлөгөө гарган ажиллаж байна. 3. Нарийн, нарийвтар ноост хонины удмын санг хамгаалах, сэргээн хөгжүүлэх зорилгоор "Хангай", "Орхон", "Тал нутгийн цагаан" хонины эх сүрэг бүрдүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх нь сэдэвт захиалагат төслийг боловсруулан Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Малын удмын сангийн үндэсний төв хамтран хэрэгжүүлэх гэрээг 2020 оны 04 дүгээр сарын 28 ны өдөр байгуулан холбогдох төслийг Боловсрол, шинжлэх ухааны яаманд хүргүүлж Шинжлэх ухаан, технологийн санаас санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн боловч шинээр хэрэгжих төслүүдийн нэг жилээр ухраах шийдвэр яам гаргасан учир хойшлогдсон. / Дээрх гэрээ, санамж бичигтэй холбогдсон 2020 оны зарим ажлууд Ковид-19 цар тахлын улмаас хойшлогдоод байгаа болно./ Аймгууд:"Архангайд үйлдвэрлэв" үзэсгэлэн худалдаа, Баян-Өлгий, Завхан аймаг Шилмэл малын үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. 	70%
63	7.1.3. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн хооронд харилцан туршлага судлах бизнес	2019 - 2023	-		1. Өвөрхангай Бат-Өлзий суманд Зөгийн аж ахуй эрхлэгчдийн зөвлөлдөх уулзалтыг Дэлхийн зөн Монгол Олон Улсын байгууллагын Өвөрхангай Орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран зохион байгууллаа. Уг зөвлөлдөх уулзалтанд Бат-Өлзий, Хархорин, Зүүнбаян-Улаан, Хужирт сумдын ХАА-н тасгийн мэргэжилтнүүд болон зөгийн аж ахуй эрхлэгчид,	70%

	аялал зохион байгуулдаг болно.				оролцож эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр болон бусад хууль дүрэм журмын талаар сургалт зохион байгуулсан. 2. Мөн 7 сумын 16 эрчимжсэн аж ахуй эрхлэгчид Төв аймгийн Баянчанадмань суманд туршлага судаллаа. Үүнд “Баян шувуу” 300,0 мянган өндөглөгчтэй шувууны аж ахуй, бордооны үйлдвэр, Сүүн далай хоршооны сүүний цех, Монбильярд үүлдрийг цэврээр нь үржүүлж буй саалийн механикжсан ферм зэрэг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцлаа. Зарим аймгууд аймаг дотроо туршлага солилцсон байна. Энэ ажилд цар тахал нөлөөлж улсын хэмжээнд зохион байгуулж амжаагүй.	
64	7.1.4. Сүүний үхрийн, хонь, ямааны эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн дунд малын нөхөн үржихүй, арчилгаа маллагаа, тэжээллэгийн мэдээлэл олгох сургалтыг тогтмолжуулна.	2019 - 2023	-		1. Эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх, ферм эрхлэгчдийг чадвахжуулах чиглэлээр 2020 онд 11 төрлийн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж, шинэ төрлийн коронавирусын халдварын улмаас Нийслэлд хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбоотойгоор ХААИС-тай хамтран сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж 143 минутын 9 удаагийн видео хичээлийг бэлтгэн явуулж 21383 иргэнийг мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. 2. Нэг хот, нэг стандарт зорилтот жилийн хүрээнд “Сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйд тавигдах ерөнхий шаардлага” MNS6723:2018 үндэсний стандартыг нийтэд хүргэх, сурталчлах ажлыг 2020 оны төлөвлөгөөнд тусган мэргэжлийн холбоод, төр, хувийн хэвшил, ферм эрхлэгчдийг хамруулан мэргэжил арга зүйгээр ханган ажиллалаа.	100%
65	7.1.5. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүү, хүний нөөц, маркетинг, хууль зүй болон бусад чиглэлээр мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг системийг бүрдүүлнэ.	2019 - 2023	-		Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүү, хүний нөөц, маркетинг, хууль зүй болон бусад чиглэлээр мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг системийг бүрдүүлэх бүрдүүлэх ажлын хувийн хэвшил, ТББ-д сайн хийж байна. Монголын сүүний нэгдсэн холбоо, Монголын үхэр үржүүлэгчдийн холбоо, Шувууны холбоо, зөгийн дээд зөвлөл гээд холбоод яамтай өдөр тутам хамтран ажиллаж мэргэжлийн зөвлөгөө авч цааш нь эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд хууль зүй болон бусад чиглэлээр мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлж байна. 2020 онд давхардсан тоогоор дээрхи холбоод 1700 гаруй иргэн аж ахуйн нэгжид зөвлөх үйлчилгээ болон мэргэжил арга зүйн зөвлөгөө үзүүлсэн мэдээ ирүүлсэн.	100%
7.2. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологийн мэргэшсэн ажилтныг бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах,						
66	7.2.1. Эрчимжсэн мал аж ахуйд технологийн мэргэшсэн ажилтан бэлтгэх, МАА-н мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, давтан сургах сургалтыг тогтмол явуулна.	2019 - 2023	--		Орон нутагт дахь мэргэжилтнүүдийн чадавхыг сайжруулах, мал үржүүлгийн техникч нарын тоог нэмэгдүүлэх, биотехнологийн дэвшилтэд аргыг ашиглан малын чанарыг богино хугацаанд сайжруулах зорилгоор бод, бог малын зохиомол хээлтүүлгийн үржүүлгийн техникч бэлтгэх сургалтыг Нийслэлийн ХХААГ, "Нутаг академи" ТББ, Бэлчээрийн менежмент төслийн нэгж зэрэг байгууллагуудтай хамтран 21-р хороо Нарийны фермер, Дархан-Уул аймгийн Хонгор суман дахь Малын удмын сангийн үндэсний цогцолборын үйлдвэрлэлийн байранд тус бүр 10 хоногийн онол, практик хосолсон сургалт зохион байгууллаа. Тус сургалтад Архангай, Өвөрхангай, Өмнөговь, Дундговь, Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Төв гэсэн найман аймгийн 16 сумын 20 мал зүйч, 10 малын эмч, 10 фермер эрхлэгч нийт 46 мэргэжилтнүүд хамрагдаж мэргэжлийн үнэмлэх сертификат гардуулан амжилттай суралцсан зарим аймгийн мэргэжилтнүүдийг бод, бог малын зохиомол хээлтүүлгийн иж бүрэн багаж төхөөрөмжөөр хангаж ажиллаа.	70%
7.3. Хөдөө аж ахуйн чиглэлийн шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд зөвлөх, нэвтрүүлэх үйлчилгээ үзүүлэх;						
67	7.3.1. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлд	2019 - 2023	-		1. “ХААҮШУОНТ” улсын төсөвт үйлдвэрийн газар нь 2020 онд Хөдөө аж ахуйн их сургууль, харьяа хүрээлэнгийн багш, эрдэмтэн зөвлөхүүдтэй гарын авлага, зөвлөгөө зөвлөмж	100%

	шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэхэд зөвлөх, нэвтрүүлэх үйлчилгээ үзүүлдэг болно.				<p>боловсруулах, сургалт зохион байгуулах чиглэлээр 12 эрдэмтэн зөвлөхтэй гэрээ байгуулан хамтран ажиллав. Төвийн www.naacs.gov.mn www.agrinfo.mn вэб сайтад мал аж ахуйн чиглэлээр зөвлөгөө боловсруулан нийт 25 мэдээлэл бэлтгэж байршуулав.</p> <p>2. Яамны зүгээс болон харьяа байгууллагууд нийтдээ 250 орчим иргэн 62 аж ахуйн нэгжид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байна.</p>	
7.5. Эрчимжсэн мал аж ахуйн ололт, амжилтыг урамшуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах;						
68	7.5.2. Шинэ техник, технологийн талаархи гарын авлага, мэдээлэл хүргэх.	2019 - 2023	-		<p>1. 2020 онд нийт 5 гарын авлага, 18 технологийн карт, нугалбар, зөвлөмж боловсруулж, цахимаар болон хэвлүүлэн нийтийн хүртээл болгов. Гарын авлага боловсруулсан тоо 2019 оноос буурч, технологийн карт, зөвлөмж боловсруулж цахимаар түгээсэн тоон үзүүлэлт өссөн дүнтэй байна. Үүнд: - Малчдад зориулсан Монгол зурхайн цаг тооны бичиг - “Газар тариалан А-Я” цувралын нэгдүгээр хэсэг “Хүлэмжний ургамал хамгаалал” - “Монгол мал маллагааны уламжлалт монгол арга ухаан” - “Мал сүргийг арчилж тордож, тэжээх уламжлалт арга” сэдэвт зөвлөмж - “Малчдад зориулсан малын эмийн зөвлөмж” - “Бэлчээр-Ногоон алт” сэтгүүл. - “Сүүний чанар, аюулгүй байдлын баталгаа” сэдэвт видео танилцуулга. - “Хүнсний зориулалттай сав баглаа боодлын зохистой хэрэглээ ба үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж” сэдэвт гарын авлагуудыг боловсруулж, хэвлүүлж, үйлдвэрлэл эрхлэгчдэд хүргүүлэв.</p> <p>2. Хүнсний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, 8.5 дахь заалтад тус тус үндэслэн “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд гарал үүсэл нь баталгаажсан эрүүл малыг, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүүг нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох” түр журмын төслийг боловсруулан яамдаас санал авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэв. 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн Засгийн газрын 130 дугаар тогтоолоор “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд гарал үүсэл нь баталгаажсан эрүүл малыг, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүүг нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох” түр журам батлагдлаа. Журам Legalinfo.mn эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд тавигдсан байна. Сүүний урамшууллын журмын сурталчилгааны шторкийг МҮОНРТелевиз-ээр 4 өдөр 2-3 удаагийн давталттай явуулсан. Журам 11-р сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж ажиллалаа. Мөн шаардлага хангасан 8 үйлдвэртэй хамтран ажиллах гэрээ байгуулан сүү бэлтгэлийн систем /СБС/-ийг 8 үйлдвэрт нэвтрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж нэвтрүүлсэн.</p>	100%
7.6. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг бүртгэх, үйл ажиллагааны чиглэлээр төрөлжсөн, шатлал ахисан зэрэг, дэв олгох, ажлын үр дүнгээр урамшуулах арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих.						
69	7.6.1. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг Малын генетик нөөцийн бүртгэлийн санд бүртгэх арга хэмжээг зохион байгуулна.	2019 - 2023	-		<p>1. Монгол Улсад баталгаажсан 52 үүлдэр, омгийн малын цөм сүргийг бүрдүүлэх, үзлэг ангилалт хийж ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, технологит хугацаанд нийт 12.9 мянган малчин өрхийн цөм сүрэгт бүртгэгдсэн 325.4 мянган малыг шинээр ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд /оффлайн, онлайн/ 1.555.2 сая малын мэдээллийг орууллаа. Мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн 1.5 сая малын 1.1 хувь 17.4 мянга нь үржлийн хээлтүүлэгч байна.</p> <p>2. "Монгол улсын малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх системийг шинэчлэх" /STDF/PG/534/ туршилтын төслийн хүрээнд Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн</p>	30%

					<p>программын туршилтыг Өвөрхангай аймгийн ХХААГазар, сумдын ХААТасаг, МҮТНэгж, төсөлд сонгогдсон Баянгол, Гучин-Ус, Бат-Өлзий, Уянга сумдын малчдыг хамруулан зохион байгуулж, 173.2 мянган малыг бүртгэлжүүлэх, Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд мэдээллийг оруулах туршилтыг амжилттай зохион байгуулав.</p> <p>3. Монгол адууны үүлдэрлэг байдалд молекул биологийн судалгаа хийх, стандартыг шинэчлэн тогтоох, хурдан морины цахим бүртгэлийн программ, мэдээллийн сан бий болгох ажлыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж, 1200 адуунд туршилтын чип суулгах, цус авах ажлыг гүйцэтгэв. Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд улс болон орон нутгийн төсөв, төслийн санхүүжүүлж ялган тэмдэглэсэн малын мэдээллийг бүрэн оруулав.</p>	
70	7.6.2. Эрчимжсэн аж ахуйд ажиллаж байгаа мэргэжилтэнд шатлал ахисан зэрэг, дэв олгох арга хэмжээг зохион байгуулна.	2019 - 2023	-		<p>Мал зүйч мэргэжилтэнд мэргэжлийн зэрэг дэв олгох асуудал нь Малын генетик нөөцийн тухай хуулийг дагалдан гарсан “Мэргэжлийн зэрэг дэв олгох, хүчингүй болгох, сунгах, бүртгэх” журмаар зохицуулагдах бөгөөд уг журмыг Малын генетик нөөцийн https://muz.gov.mn/law...ew/35 вэб сайтад байршуулж аймаг, нийслэлийн ХХААГ-аас мэргэжлийн зэрэг дэв авах шаардлага хангасан мал зүйчдийн материалыг хүлээн авч нэгтгэв. Зэрэг дэв авах хүсэлтээ нийт 9 аймаг, нийслэлээс 43 мал зүйчид хүсэлт гаргасан бөгөөд материалын бүрдлийг анхаарч хүлээн авав. Ирүүлсэн материалыг хянан үзэж журмын дагуу шаардлага хангасан нийт 28 хүний материалыг Малын генетик нөөцийн үндэсний зөвлөлдөх хорооны ээлжит хурлаар хэлэлцүүлэв. Уг хуралдаанаар 11 мал зүйчид зөвлөх малзүйч, 18 мал зүйчид тэргүүлэх зэргийг олгохоор шийдвэрлэн хуралдааны дүгнэлт гарав. Малын генетик нөөцийн үндэсний зөвлөлдөх хорооны хурлын шийдвэрийг үндэслэн ХХААХҮСайдын 2020 оны 12 сарын 17-ны өдрийн А-386 дугаар тушаалаар зөвлөх зэрэг 11 хүнд, тэргүүлэх зэрэг 18 хүнд тус тус олгосон.</p>	70%

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ